

Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛД ДАГАЖ МӨРДӨХ ХӨДӨЛМӨР
ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ.

I хэсэг. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

БНБД 12-03-04

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ЯАМ
Улаанбаатар хот 2004 он

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ
БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛД ДАГАЖ МӨРДӨХ ХӨДӨЛМӨР
ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ.

I хэсэг.ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
OCCUPATIONAL SAFETY IN CONSTRUCTION PART ONE.
GENERAL SAFETY REQUIREMENTS

2004-оны....дугаар сарын....ны
өдрөөс эхлэн мөрдөнө.

1.Хэрэглэх хүрээ

Энэхүү норм ба дүрмийг барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөж шинэчлэх, сэргээн засварлах, техникийн шинэчлэлт болон их засвар хийх (цаашид барилгын үйлдвэрлэл гэх), барилгын материалын үйлдвэрлэл, машин механизм, тоног төхөөрөмжийн аж ахуй, түүнчлэн барилгын бүтээц, эдлэхүүний үйлдвэрлэл (цаашид барилгын үйлдвэр) эрхлэн гүйцэтгэдэг бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд харъяалал, өмчийн хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

2.Норматив ишлэл

Энэ норм ба дүрмийг хавсралт А ба Л -д заасан норматив баримт бичгүүд болон бусад баримт бичгийг ишлэл болгон боловсруулав.

3.Тодорхойлолт

Энэхүү норм ба дүрэмд хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, БНБД 10-01-99, MNS 4967:2000, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 148, 155 дугаар конвенци, хавсралт Б-д заасан нэр томъёо ба тодорхойлолтыг хэрэглэсэн болно.

4.Ерөнхий зүйл

4.1.Барилга угсралт, материалын үйлдвэрлэл, машин механизм, тоног төхөөрөмжөөр ханган үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагад энэхүү норм, дүрмийн шаардлагыг заавал дагаж мөрдөнө.

4.2.Барилга угсралтын ажилд барилгын материал, бүтээц хийц хэсэг, машин механизм, тоног төхөөрөмж, технологийн тээврийн хэрэгсэлийг хэрэглэх үед түүний аюулгүй ажиллагааны шаардлага нь энэхүү дүрэмд тусгагдаагүй байвал 4.3-р зүйлд заасан норматив баримт бичгүүдийн шаардлагыг мөрдлөг болговол зохино.

4.3.Барилгын үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэр, барилгын үйлдвэрт "Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо. Үндсэн журам" БНБД 10-01-99-тай нийцсэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норматив баримт бичгийн зэрэгцээгээр дор дурдсан бичиг баримтыг мөрдөнө. Үүнд:

- Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмаар боловсруулсан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны салбар хоорондын дүрэм болон бусад норматив, эрх зүйн акт;

- Монгол Улсын стандартчилалын тогтолцооны суурь стандарт /MNS 1-1, 2, 3/-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан улсын стандарт болон бусад баримт бичиг;

- Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын норм ба дүрэм;

- Салбарын стандарт, барилга байгуулалтын тусгай мэргэжлийн болон үйлдвэрлэлийн төрлөөр гаргасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, яам,албан байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд мөрдөж байгаа бусад баримт бичгүүд;

- Үйлдвэр, албан газар (байгууллага), аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт, байгууллагын ажилтнуудад зориулсан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар.

Тайлбар:

- БНМАУ-ын барилгын яам, албан байгууллагын үед батлагдсан, одоогоор хүчинтэй мөрдөж байгаа үйлдвэрлэлийн ариун цэвэр, техникийн аюулгүй ажиллагааны нарийн

мэргэжлийн дүрэм, стандарт болон барилга дахь хөдөлмөр хамгааллын бусад норматив баримт бичгүүдийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм болон энэхүү норм, дүрэмтэй зөрчилдөхгүй бол хэсэгчлэн хэрэглэхийг зөвшөөрнө.

4.4.Үйлдвэрлэлийн салбар дахь байгууллагын нормативын баримт бичгүүдэд агуулагдаж буй хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагууд нь энэхүү норм, дүрмийн заавал мөрдөх заалтууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар, үйлдвэрлэгч-заводуудын техник хэрэгслийн ашиглалтын заавар, бусад төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нормативын бусад баримт бичгүүдтэй зөрчилдөж болохгүй.

4.5.Объектын барилга байгуулалтад оролцогчид (захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, тээвэрлэгч, машин механизмаар ханган үйлчлэгч түүнчлэн барилгын материал, бүтээцийг үйлдвэрлэгчид, барилгын техник үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг бүтээгчид) энэхүү норм ба дүрмийн шаардлагыг зөрчвөл хуулиар тогтоосон хариуцлагыг хүлээнэ.

Эдгээр шаардлагуудыг биелүүлэх барилгын үйлдвэрлэлд оролцогчдын үүргийг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль дүрмээр тодорхойлж, талуудын хооронд байгуулсан гүйцэтгэх, бэлтгэн нийлүүлэх, түрээс болон бусад ажил үйлчилгээний гэрээ, түүнчлэн ажил гүйцэтгэх тухай актуудаар тогтооно.

4.6.Машин, төхөөрөмж, цахилгаан болон хийн ажиллагаат гар багаж, технологийн тоноглолын ашиглалтад тавигдах аюулгүй ажиллагааны талаар хүлээх үүрэг хариуцлагыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Барилгын машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологийн тоноглол, түүний хамгаалах хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг тухайн эд хөрөнгийг эзэмшигч байгууллага, харин тэдгээрийг түр хэрэглүүлэх (түрээс)-ээр шилжүүлсэн үед түрээслэгч байгууллага (хувь хүн) хариуцна.

- Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны бүх шаардлагыг уг ажлыг гүйцэтгэж буй байгууллага хариуцна.

4.7.Ерөнхий гүйцэтгэгч буюу түрээслэгч нь үйлдвэрлэлийн талбай дээр туслан гүйцэтгэгч, түрээслэгчдийн оролцоотойгоор ажил гүйцэтгэхдээ:

- тухайн үйлдвэрлэлийн талбай дээр бүх байгууллага, хувь хүний ажиллах аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний төлөвлөгөөг тэдэнтэй хамтран боловсруулах;

- газар шорооны болон барилга угсралтын ажлын бэхэлгээний ажлын хэсэг дээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэхдээ туслан гүйцэтгэгч болон түрээслэгчдийн ажиллах байр болон тэдэнд зориулан төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг хангуулах үүрэг хүлээнэ.

4.8.Байгууллага, хорооллын нутаг дэвсгэр дээр барилга угсралтын ажил гүйцэтгэхийн өмнө захиалагч, ерөнхий гүйцэтгэгч болон тухайн объектыг ашиглагч байгууллага хавсралт В -д үзүүлсэн загварын дагуу ажил гүйцэтгэх тухай зөвшөөрлийн акт /баримт бичиг/ -ыг заавал бүрдүүлсэн байна.

Уг баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг дагаж мөрдүүлэх үүргийг ажилд оролцогч барилга угсралтын байгууллага болон ажиллаж байгаа үйлдвэрийн газрын удирдлага хүлээнэ.

4.9.Ажил эхлэхийн өмнө үйлдвэрлэлтэй холбогдон осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн гэж үзвэл ажилтнуудад анхааруулж, аюултай бүсийг тогтоож, энэхүү гүйцэтгэх ажлын онцлогт хамаарах болон үл хамаарах хүчин зүйлс бусад нөлөөллийг сайтар харгалзвал зохино.

4.10.Байнгын үйлчлэл бүхий үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн хүрээнд:

- цахилгаан дамжуулах төхөөрөмжийн хаалт, хамгаалалт, тусгаарлалтгүй хэсгийн ойролцоох ажлын байр;

- 1.3 м ба түүнээс дээш өндөрт байрлаж буй хамгаалалтгүй ажлын байрууд;

- ажил явагдаж байгаа бүсийн агаар дахь хорт бодисын бөөгнөрөл зөвшөөрөгдөх хэмжээнээс их байж болох ажлын байр, орчин хамаарагдана.

Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд тохиолдож болзошгүй бүсэд:

- барьж байгаа барилга, байгууламжийн ойролцоох талбай, нутаг дэвсгэр;
- нэг үе шатны ажил дахь хийц хэсэг, бүтээц, тоног төхөөрөмжийг угсрах (задлах, буулгах) ажил хийгдэж байгаа барилга, байгууламжийн давхарууд (ярус);
- Машин, тоног төхөөрөмж болон тэдгээрийн эд анги, ажлын ээлжийн, тоноглолын хөдөлгөөний шилжилтийн бүсүүд;
- Кранаар ачаа өргөж шилжүүлж байгаа орчны газрууд хамаарагдана.

Аюултай бүсийн хязгаарын зай хэмжээг хавсралт Г-д үзүүлсний дагуу тогтооно.

4.11.Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд байнга үйлчилж болох бүсийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хаалт хамгаалалтаар, харин үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд тохиолдож болзошгүй бүсийг дохио, санамж анхааруулга, аюулгүйн тэмдэг бүхий хаалтаар хашиж тусгаарласан байвал зохино.

4.12.Гүйцэтгэх ажлын онцлогтой холбоогүйгээр үүсэх үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд үйлчлэх бүсэд ажлыг гүйцэтгэхдээ хавсралт Д -д үзүүлсэн загварын дагуу ажил гүйцэтгэх зөвшөөрлийг заавал бүрдүүлнэ.

4.12.1.Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг заавал авч байж, гүйцэтгэхийг зөвшөөрөх ажлын төрөл болон үйлдвэрлэлийн байрны үлгэрчилсэн жагсаалтыг хавсралт Е -д үзүүлсэн загварыг үндэслэн боловсруулж, аж ахуйн нэгж, байгууллагын захиргаагаар батлуулсан байвал зохино.

4.12.2.Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тушаалаар томилогдсон ажил удирдан гүйцэтгэгч (барилгын талбайн даамал, хэсгийн инженер, хэсэг хариуцсан ахлагч г.м) -д өгнө. Ажил эхлэхийн өмнө ажил удирдан гүйцэтгэгч, ажилчдад аюулгүй ажиллагааны арга хэмжээтэй заавал танилцуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл дээрх зааварчилгааг албан ёсны болгон гарын үсэг зуруулж хадгална.

4.12.3.Барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх үед, ажил гүйцэтгэх зөвшөөрлийг, тэдгээр барилга байгууламж, шугам сүлжээг эзэмшигч - байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн олгож болно.

4.12.4.Ажил гүйцэтгэх зөвшөөрөлд уг ажлыг хийж дуусгах хугацааг заана. Ажил гүйцэтгэх явцад зөвшөөрөлд урьдчилан заагаагүй аюултай буюу хортой хүчин зүйлс илэрсэн тохиолдолд, ажлыг даруй зогсоож, ажил гүйцэтгэх зөвшөөрлийг хүчингүй болгох ба ажлыг зөвхөн шинээр зөвшөөрөл олгосны дараа дахин үргэлжлүүлнэ.

Ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгосон албан тушаалтан уг ажлыг гүйцэтгэх явцад ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж байх үүрэгтэй.

4.13.Ажлын онцлогтой холбоотойгоор үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн үйлчлэлд ажиллаж байгаа ажилтнуудад аюулгүй ажиллагааны нэмэгдэл шаардлага тавигдана. Ийм нэмэгдэл шаардлага тавигдах ажил мэргэжлийн жагсаалт, барилга угсралтын ажлын нэр төрлийг хавсралт Ж-д заасан үлгэрчилсэн жагсаалтыг үндэслэн боловсруулж, байгууллага, аж ахуйн нэгж батлан мөрдөнө.

Энэхүү хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэмэгдэл шаардлага тавигдах ажлыг зөвхөн мэргэжлийн дадал, эв дүй эзэмшсэн, аюулгүй ажиллагааны аргыг зохих ёсоор сурч, холбогдох мэргэжлийн үнэмлэх авсан 18-аас дээш насны хүмүүсээр гүйцэтгүүлнэ.

4.14.Эмнэлгийн урьдчилсан үзлэгт тэнцсэн, нэгээс доошгүй жил өндөрт ажилласан туршлагатай, мэргэжлийн 3-аас доошгүй зэрэгтэй, 18-аас дээш насны ажилчид, инженер техникийн ажилтнуудыг өндөрт бие даан угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Анх удаагаа өндөрт ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгосон ажилчинг, аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тушаалаар томилогдсон туршлагатай ажилтны байнгын хяналтын дор нэг жилийн хугацаанд ажиллуулна.

4.15.Тухайн газар нутагт салхины хүч маш их, гадна агаарын хамгийн их нэмэх, хасах

температурын үед барилгын ажил гүйцэтгэхийг зогсоох, дулаалгагүй тээврийн хэрэгслэлээр хүн тээвэрлэхийг хориглох асуудлыг ажил явагдаж байгаа тухайн орон нутгийн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохицуулна.

4.16.Насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг нийтлэг мөрдөж буй хууль тогтоомж, норм дүрмийг үндэслэн өргөх, зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажил, мэргэжлийн жагсаалтад заасан хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөл, хязгаарлалтыг мөрдлөг болгоно.

4.17.Мэргэжлийн анхан, дунд шатны болон ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдыг аюулгүй ажиллагааны нэмэгдэл шаардлага тавигдах ажилд татан оролцуулахыг хориглоно.

Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөл, ажил мэргэжлийн жагсаалтад заасан ажил дээр үйлдвэрлэлийн дадлага (үйлдвэрлэлийн сургалт) хийгч нь өдөрт 4-өөс илүүгүй цагаар СанПиН 2.4.6.664-ийн шаардлагыг сахин биелүүлсэн нөхцөлд ажиллахыг зөвшөөрнө.

4.18.Үйлдвэрлэлийн хүнд ба хортой хүчин зүйлсийн үйлчлэлд ажил хийж байгаа ажилтныг холбогдох Төрийн захиргааны төв байгууллагаас батласан журмын дагуу ажилд орохын өмнө урьдчилсан үзлэгт заавал, ажилд орсны дараа эмнэлгийн хугацаат үзлэгт тогтмол оруулж байвал зохино.

4.19.Барилгын ажил гүйцэтгэх төсөл (АГТ) боловсруулах, батлах эрх бүхий байгууллага нь хавсралт К -д заасан шаардлагын дагуу барилгын ажлыг аюул осолгүй гүйцэтгэх үндсэн шийдлийн агуулга, хөдөлмөрийг аюул осолгүй зохион байгуулах асуудлыг АГТ-д тодорхой тусгасан байвал зохино. БУИЗА-ын ажлыг аюулгүй гүйцэтгэх арга ажиллагааг тусгасан АГТ-гүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

4.20.Цахилгаан техник, технологийн тоног төхөөрөмжийг ажиллуулагчид нь цахилгаан төхөөрөмжийн ашиглалтын дүрмийн шаардлагыг мөрдөнө.

4.21.Асбест ба асбестын агуулга бүхий материал дээр ажил гүйцэтгэх үед ОУХБ-ын 162 - р конвеци, СанПиН 2.2.3.757-99-ийн шаардлагыг мөрдөнө.

5.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах ажлын зохион байгуулалт.

5.1.Мөрдөж буй хууль, дүрэмтэй нийцүүлэн байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүргийг ажил олгогч хариуцна.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах ерөнхий удирдлага нь байгууллагын дарга, эсхүл байгууллагаас томилсон албан тушаалтанд оногдоно.

5.3.Ажилтан нь ажил олгогчийн баталсан байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг заавал биелүүлэн ажиллана.

Ажилтанг ажилд орох, эсхүл өөр ажилд шилжүүлэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг танилцуулж, гарын үсэг зуруулж хувийн хэрэгт хадгална.

5.4.Ажил олгогчийн төлөөлөгч, ажилтнууд нь хууль дүрэмд нийцүүлэн холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас батласан зөвлөмжийн дагуу, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны гэрээ хэлэлцээр, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

5.5.Байгууллагын захиргааны тушаалаар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий ажилтанг эрхэлсэн ажлынх нь хүрээнд хариуцуулан томилно. Үүнд:

- Байгууллагын хэмжээнд орлогч дарга, ерөнхий инженерийг;
- Бүтцийн салбар нэгжид салбар нэгжийн удирдагчийг;
- Үйлдвэрлэлийн талбай дээр цех, хэсгийн ахлагч, барилгын талбайн даамлыг;
- Машин,тоног төхөөрөмжийн ашиглалт дээр ерөнхий механик,ерөнхий цахилгаанчныг;
- Ажлын байранд менежер, хэсгийн инженер, ахлагчийг тус тус томилно.

5.6.Байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хариуцсан албан тушаалтан, салбар нэгжийн үйл ажиллагааны зохицуулах арга зүйн удирдлагын бүтцэд зориулж, албан газрын дэргэд орон тооны, эсхүл гэрээний үндсэн дээр оролцогч, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн албыг байгуулвал зохино. Энэхүү хөдөлмөрийн

аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн албаны бүтэц, орон тоо, түүнчлэн түүний гүйцэтгэх үүрэг, зорилгыг мөрдөж буй хууль дүрэм болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас батласан зөвлөмжийг баримтлан тодорхойлно.

5.7.10-аас илүү тооны ажилтантай байгууллага нь байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч буюу бусад төлөөллийн байгууллагын бүрэн эрхт ажилтнаас бүрдсэн хөдөлмөр хамгааллын хамтарсан зөвлөл (комисс) - ийг тэгш эрхийн үндсэн дээр байгуулвал зохино.

5.8.Мөрдөж байгаа хууль дүрмийн хүрээнд байгууллагадаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн норматив эрх зүйн акт, хууль дүрмийн шаардлагыг ажил олгогч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч болон бусад төлөөллийн байгууллагын бүрэн эрхт ажилтныг сонгож болно. Гэхдээ тэдний үүрэг, зорилго, зохион байгуулалт нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан зөвлөмжтэй нийцэж байвал зохино.

5.9.Байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх болон хяналт, шалгалт хийх ажлыг, дор дурдсан хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

- Ажилтнуудын, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажил эхлэхийн өмнө, ажлын явцад багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хаалт хашлага, газардуулга бусад хамгаалалтын хэрэгслүүдийн хамгаалалт, бүрэн бүтэн байдалд тавих тогтмол хяналт;
- Аж ахуйн нэгж, байгууллагын болон салбар нэгжийн удирдагчдын, ажил үүргийнхээ дагуу явуулах, удирдлагын шуурхай үзлэг шалгалт;
- Аж ахуйн нэгж, салбар нэгжүүдэд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон хөдөлмөрийн нөхцөл байдлыг шалгах түүвэрчилсэн хяналт зэрэг болно.

Ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн норм дүрмийн зөрчлийг илрүүлсэн даруйдаа түүнийг өөрийн биеэр арилгах арга хэмжээг авах ёстой бөгөөд боломжгүй тохиолдолд ажлыг зогсоож, тухайн асуудал хариуцсан албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн асуудал хариуцсан албан тушаалтан нь ажлыг зогсоож, аюул ослыг зайлуулах арга хэмжээг авах, зайлшгүй тохиолдолд хүмүүсийг аюулгүй газар руу нүүлгэн шилжүүлэх бололцоог хангах үүрэгтэй.

5.10.Аж ахуйн нэгж, байгууллагууд тогтоосон журмын дагуу үйлдвэрлэлийн- салбарын хөдөлмөр хамгаагч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаархи дор дурдсан нормативын баримт бичгүүдийг боловсруулж, албан ёсны болгон, хэвлэн тарааж, хадгалах ёстой. Үүнд:

- Барилгын талбайн зохион байгуулалт, материалын үйлдвэр, машин механизмын аж ахуй, орон сууц, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн эрүүл ахуйн үлгэрчилсэн стандартын загвар (СП12-132-99)-ыг үндэслэн боловсруулсан үйлдвэр (байгууллага)-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт;
- Барилга угсралт, материалын үйлдвэр болон орон сууц, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудад зориулсан салбарын ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар хамрагдана.

5.11.Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа дор дурдсан шаардлагуудыг баримтлан ажилтнуудаа тухай бүр сургалтанд хамруулж байх үүрэгтэй.

5.11.1.Байгууллагын захиргааны тушаалаар батлагдсан албан тушаалтан, удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгийг эрхэлсэн ажлынх нь онцлог байдлаас хамааруулан ажилд орохын өмнө болон цаашид тогтоосон хугацаанд тогтмол шалгаж байвал зохино.

5.11.2.Тухайн ажлыг гүйцэтгүүлэхээр томилсон ажилтан нь урьд өмнө нь мэргэжлээрээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж байгаагүй

бол ажилд авсан өдрөөс хойш сарын дотор, салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн зааврын үндсэн дээр, MNS 4969:2000-ыг баримтлан сургалтад хамруулбал зохино.

Сургалтын хугацаа дууссаны дараа, цаашид жил бүр, мөн нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжиж ирэх үед буюу хариуцлага алдах, хяналтын байгууллагын шалгалтаар илрүүлсэн доголдол дутагдлын үед тухайн ажилтнаас байгууллагын удирдлагын тушаалаар батлагдсан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавраар шалгалт авч байх хэрэгтэй. Ажил олгогчийн тушаалаар томилогдсон комисс мэргэжил мэдлэгийн шалгалтыг авна. Шалгалтын үр дүнг тусгай дэвтэрт хөтөлж үнэмлэх (гэрчилгээ) олгож байвал зохино.

5.11.3.Шинэрт ажилд орсон ажилтныг ажилд орохын өмнө MNS 4969:2000-д заасны дагуу урьдчилсан болон ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг заавал өгөх үүрэгтэй.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг 3 сард нэгээс доошгүй удаа бүх ажилтнуудад өгч байвал зохино. Өөр байгууллагын газар нутаг дээр ажил гүйцэтгэж байх үед зааварчилгааг тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан албан тушаалтанг байлцуулан өгөх хэрэгтэй.

5.11.4.Байгууллага нь ажилтнууддаа үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тухайн төрөлд нэвтэрч байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа, шаардлага ба дүрмийг бие даан судлах нөхцөл бололцоог бүрдүүлж өгвөл зохино.

Аж ахуйн нэгж, байгууллагынхаа үйлдвэр, салбар бүрд, ажилтнуудын бие даан судлахад зориулагдсан, төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон иж бүрдэл баримт бичгүүд заавал байна.

5.12.Машин механизм, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд нь хяналт шалгалтын байгууллагуудаас тавигдаж байгаа шаардлагыг хангасан нөхцөлд, тэдгээрийг ажилд гарахыг зөвшөөрнө.

5.13.Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн анхан ба дунд шатны сургуулийн сурагчид, түүнчлэн дээд сургуулийн оюутнууд үйлдвэрлэлийн дадлага хийх, эсхүл гэрээгээр ажил гүйцэтгэх үед, байгууллагын захиргаа зохион байгуулалтын дараах арга хэмжээнүүдийг авах үүрэгтэй. Үүнд:

- ажилд томилох тухай тушаал нь ажилтнуудад зориулсан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу ажлыг хийх арга, аюулгүй ажиллагааны арга барилд сургаж, хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг хангах;

- ариун цэвэр-эрүүл ахуйн үйлчилгээгээр хангах, тэдэнд үнэ төлбөргүйгээр ажлын тусгай хувцас,бие хамгаалах хэрэгслээр хангах;

- тушаалаар ажилд томилоогүй ажилтнуудыг ажиллуулахыг хориглох зэрэг болно.

5.14.Ажил олгогч нь хөдөлмөрийн хүнд хортой, аюултай бохирдол бүхий нөхцөлд ажилтнуудад ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй. Барилгын талбайд ажиллаж байгаа бүх хүмүүс нь хамгаалалтын дуулга малгай өмсөнө.

Хамгаалалтын дуулга малгай,бусад шаардагдах нэг бүрийн хамгаалах хэрэгсэлгүйгээр ажилд гарахыг хориглоно.

5.15.Ажил олгогч нь барилгын угсралт, их засвар, материалын үйлдвэр, барилгын бусад үйлдвэрлэлийн ажилтнуудыг "Захиргаа ба аж ахуйн барилга"НБД 31-04-03 норм ба дүрэм болон хамтын гэрээ буюу зөвшөөрөгдсөн журмын дагуу ариун цэвэр - ахуйн үйлчилгээний байр (өлгүүр, гутал, хувцас хатаах, усанд орох, хоол унд идэж уух, амрах, дулаацах болон бусад)-аар хангах үүрэгтэй. Барилга барих газарт, барилга угсралтын ажлыг эхлэхийн өмнө ариун цэвэр, ахуй үйлчилгээний байрыг барьж бэлтгэн, ашиглахад бэлэн болгосон байвал зохино.

Ажиллаж буй үйлдвэрийн ариун цэвэр-ахуйн үйлчилгээний байрны зохион байгуулалтыг өөрчилж, засварын ажил хийхдээ, ариун цэврийн шаардлагыг заавал

тооцож, уг засварыг гүйцэтгэнэ.

Ариун цэвэр - ахуйн үйлчилгээний байрны бүрэлдэхүүнд үйлдвэрлэлийн осолд өртөгсдөд анхны тусламж үзүүлэхэд зориулагдсан эмийн сан, дамнуурга, чиг барьж боох болон бусад шаардлагатай багаж хэрэгсэл бүхий булан гаргавал зохино.

5.16.Ажил олгогч нь осол болон мэргэжлийн өвчлөлийн тохиолдол бүрийг энэхүү дүрмийн хавсралт А-д заасан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийг баримтлан, судалгааны ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Ослын шалтгааныг судалснаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулан биелэлтийг хангах үүрэгтэй.

5.17.Ажил олгогч нь хөдөлмөрийн болон бусад хяналт, шалгалтын байгууллагад хөдөлмөр хамгааллын холбогдол бүхий бичиг баримтуудыг танилцуулах, үйлдвэрлэлийн газар нутаг, үйлдвэрлэл, ариун цэвэр-ахуйн үйлчилгээний байр сууц болон ажлын байранд эдгээр байгууллагуудын төлөөлөгчдийг саадгүй нэвтрүүлэх үүрэгтэй.

5.18.Ажил олгогч нь ажлын байрны аттестатчиллыг явуулах, байгууллага дахь хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцлийг гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Ажлын байрны аттестатчиллыг хөдөлмөр хамгааллыг хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу явуулна.

6.Үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсэг, ажлын байрны зохион байгуулалт

6.1.Ерөнхий шаардлага

6.1.1.Үйлдвэрлэлийн нутаг дэвсгэр (барилга объект, үйлдвэрлэл, ариун цэвэр, ахуй үйлчилгээний барилга байгууламж, барилгын талбай), ажлын хэсэг, ажлын байр нь үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангахад зориулагдан бэлтгэгдсэн байх ёстой.

Бэлтгэл ажлууд нь барилгын ажил эхлэхээс өмнө бүрэн хийгдэж дууссан байвал зохино.

Барилгын талбай дээрх бэлтгэл ажил нь хавсралт И-д үзүүлсэн маягтын дагуу хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээний гүйцэтгэлийн тухай акт үйлдсэнээр дуусгавар болно.

6.1.2.Ажлын байрны зохион байгуулалтад хэрэглэгдэж байгаа үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байвал зохино.

6.1.3.Үйлдвэрлэлийн талбай, хэсэг ажлын байрыг ажиллагсадын нэг бүрийн буюу нийтийн хамгаалах болон гал унтраах анхан шатны хэрэгсэл, түүнчлэн дохиолол, холбооны хүчин төгөлдөр мөрдөж буй норматив баримт бичиг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах бусад техник хэрэгслээр хангагдсан байна.

6.1.4.Үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсгийг тохижуулахдаа ажиллагсадын тогтмол буюу түр байрлах газар (эрүүл ахуйн болон амрах байр, гарц)-ыг аюултай бүсийн гадна байрлуулбал зохино.

6.1.5.Үйлдвэрлэлийн талбай дээрх зам, гарц, түүнчлэн ажлын байр руу очих зам ба ажлын байр нь эмх цэгцтэй, цэвэр цэмцгэр байдлыг хадгалахын зэрэгцээ, хог, цаснаас цэвэрлэгдсэн, хураалттай материал ба бүтээцээр дүүргээгүй байвал зохино.

6.1.6.Үйлдвэрлэлийн талбайд гадны хүмүүс, мансууралын байдалтай буюу тухайн талбайд ажиллах ёсгүй ажилтанг нэвтрүүлэхийг хориглоно.

Барилгын үйлдвэрлэлийн талбай дээр ахуйн үйлчилгээ, ажлын байранд байж байх үедээ ажилтнууд, түүнчлэн бусад байгууллагын төлөөлөгчид нь тухайн байгууллагад мөрдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг биелүүлэх үүрэгтэй.

6.1.7.Алс зайтай байрласан байр, талбай, хэсэг, ажлын байрыг утсан болон радио холбоогоор хангасан байна.

6.2.Үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсэг, ажлын байрны аюулгүй ажиллагааны шаардлага

6.2.1.Үйлдвэрлэлийн талбайн төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, техникийн ашиглалт нь барилгын норм дүрэм, улсын стандарт, эрүүл ахуй, галын аюулгүйн шаардлага, байгаль орчны болон бусад нормативын баримт бичгийн шаардлагыг хангаж байвал зохино.

6.2.2.Суурин газар буюу байгууллагын нутаг дэвсгэр дээрх үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсэг нь гадны хүмүүсийн нэвтрэх боломжийг хязгаарласан хашаагаар хамгаалагдсан байна.

Хамгаалалтын хашаа нь дараахи шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн талбайн хайс, хашааны өндөр нь 1.6 м-ээс, харин ажлын хэсгийн хайсны өндөр нь 1.2 м-ээс багагүй байна.

- Хүмүүс олноор 5орчих газарт тулгаж тавьсан хашлага нь 2 м-ээс багагүй өндөртэй байхаас гадна, хамгаалалтын үргэлжилсэн саравчаар тоноглогдсон байвал зохино.

- Саравч нь цасны болон бусад ачааллын үйлчлэлийг даахаар тооцогдон хийгдсэн байна.

- Хашлага нь ажил гүйцэтгэх хугацааны турш хяналт тавьж байх зориулалттай, ажил дууссаны дараа хааж түгжигддэг явган болон дааман хаалгатай байна.

6.2.3.Аюултай бүсийн хүрээн дэх хүмүүс зорчих хэсэг нь хамгаалалтын хашлагатай байна. Барьж байгаа барилга (байгууламж) руу орох хаалганууд нь барилгын хананаас 2м-ээс багагүй өргөнтэй саравчаар дээд талаасаа заавал хамгаалагдсан байна. Саравч нь орох хаалганы дээд талын ханатай 70-75°-ийн налуутай байвал зохино.

6.2.4.Хаалттай байр сууц, өндөрт, мөн түүнчлэн газрын гүнд ажил гүйцэтгэхдээ галын аюул осол гарч болзошгүй тохиолдолд хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг урьдчилан тооцсон байвал зохино.

6.2.5.Үйлдвэрлэлийн талбай руу орох хаалганы дэргэд талбайн доторх зам, материал хийц хэсэг, бүтээцийг хураах газрыг заасан гарц, тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөн, гал, усан хангамжийн объектын тойм зургийг заавал байрлуулсан байна.

6.2.6.Үйлдвэрлэлийн талбайн доторх автомашины зам нь СНиП 2.05.07, СНиП II-89-80*-ийн шаардлага, "Монгол улсын авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм"-д нийцэж, замын хөдөлгөөний замын зохих тэмдгүүдийг байрлуулсан байвал зохино.

6.2.7.Ариун цэвэр-ахуйн үйлчилгээний зөөврийн барилга, байгууламжийн ашиглалт нь бэлтгэн нийлүүлэгчийн болон бусад заавартай нийцэж байвал зохино.

6.2.8.Үйлдвэрийн барилга нь энэхүү дүрмийн хавсралт А-д заасан СНиП 2.09.02-тай, харин түүний ашиглалт нь "Барилга, материалын үйлдвэрийн барилга, байгууламжийн техник ашиглалт, төлөвлөгөөт урьдчилсан засвар явуулах тухай журам"-тай нийцсэн байх ёстой.

6.2.9.Оршин суугчид олноор суурьшсан нутаг дэвсгэр буюу үйлдвэрлэлийн талбай дээр хүнхээл, нүх, суваг, шуудуу ухах зэрэг газар шорооны ажил гүйцэтгэхдээ, хүмүүсийн болон тээврийн хөдөлгөөн ихтэй газруудад 6.2.2 дугаар зүйлд заасан шаардлагатай нийцүүлэн хаалт, хамгаалалт хийж өгвөл зохино.

Нүх, суваг, шуудуу дээгүүр хөндлөн гарах газруудад 0.15 м зузаан үргэлж тавцантай, тавцангаасаа 0.5 м өндөрт нэмэлт хаалттай, хоёр талдаа 1.1 м-ээс багагүй өндөр хашлагатай, 1 м-ээс багагүй өргөн гүүрэн гарц байрлуулж өгөх хэрэгтэй.

6.2.10.Үйлдвэрлэлийн талбай, хэсэг, байранд ажилтнуудыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж өгвөл зохино.

6.2.11.Үйлдвэрлэлийн талбай, хэсэг, байр, зам талбай, орцыг шөнийн цагт ГОСТ 12.1.046 стандартын шаардлагын дагуу гэрэлтүүлсэн байх шаардлагатай. Хаалттай байрны гэрэлтүүлэг нь СНиП 23-05-95 нормын шаардлагыг хангасан байна.

Гэрэлтүүлэг нь ажиллагсадын аюулгүй ажиллах нөхцөлийг бүрэн хангахуйц, бүх

талбайг жигд, нүд гялбахгүйгээр хурц тод гэрэлтүүлж байх ёстой. Гэрэлтүүлэггүй газар ажил гүйцэтгэхийг хориглоно.

6.2.12.Ил задгай газар ажиллагсдад зориулж хур тунадаснаас хамгаалах хорго буюу саравчийг урьдчилан төлөвлөсөн байвал зохино.

6.2.13.Ил задгай газар буюу халаалтгүй байранд ажиллагчдын ажлын байрны агаарын температур 10° -аас доош болсон үед дулаацах байраар хангаж өгнө.

6.2.14.Ухмал худаг, өрөмдсөн газар, бусад малтаас зэрэг газруудыг таг, халхавч, хаалтаар хаасан байх ёстой. Шөнийн харанхуй үед 42 В-оос дээшгүй хүчдэлтэй дохионы цахилгаан чийдэнгээр тэр орчныг гэрэлтүүлсэн байвал зохино.

6.2.15.Усан дээр буюу усан доор ажил гүйцэтгэх үед аврах өртөө (аврах байр) –г зохион байгуулсан байх шаардлагатай. Усан дээр ажил гүйцэтгэгч бүх хүмүүс нь сэлж чаддаг ба аврах хэрэгслээр хангагдсан байх ёстой.

6.2.16.1.3м-ээс дээш өндөрт хучилт, хучлага дээр байрлаж байгаа ба өндрөөс унаж болох бүсийн хилээс (ирмэгээс) 2 м-ээс багагүй зайнд байгаа ажлын байр болон түүн рүү хүрэх замыг хамгаалалтын хаалтаар хашиж өгвөл зохино. Харин 2м-ээс илүү зайд байгаа бол ГОСТ 12.4.059 -ын шаардлагын дагуу дохиололтой хаалт хийж өгөх ёстой.

6.2.17.Зөвхөн нэг талаас нь хучилт (хучлага) нийлж байгаа ханан дахь нүхийг, хэрэв хучилтын түвшинээс нүхний доод ирмэг хүртэлх зай нь 0.7м-ээс бага бол, хайсаар хааж хамгаалсан байвал зохино.

6.2.18.Хамгаалалтын хаалтыг хэрэглэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй буюу 6.2.16 дугаар зүйлд заасны дагуу хэрэглэх боломжгүй үед ажил гүйцэтгэх зөвшөөрлийн бичигтэй нөхцөлд ГОСТ Р 50849-96* дагуу хамгаалалтын бүсийг ашиглан ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.

6.2.19.Ажлын байр хүртэлх, ажлын байранд байх гарц нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Ажлын байр хүртэлх, ажлын байранд байх хонгил, замын өргөн 0.6 м-ээс багагүй, өндөр нь 1.8 метрээс намгүй байх ёстой.

5м-ээс дээш өндөрт байрлах ажлын байр руу ажилтнуудын дээш өгсөн, уруудахад зориулагдсан шат буюу бариул нь хамгаалалтын бүсний уяаг (тогтоогуртай татлагаар болон бусад) бэхлэх төхөөрөмжөөр тоноглогдсон байвал зохино.

6.2.20.Ажлын байр нь хучилт дээр байрлаж байгаа үед хадгалагдаж байгаа материал, тоног төхөөрөмж, тоноглол хэрэгсэл болон хүмүүсээс хучилтад үзүүлэх ачаалал нь барилгын даацын бүтээцийн бодит байдлыг тооцож зураг төсөлд урьдчилан заасан тооцоот ачаалалаас хэтрэхгүй байна.

6.2.21.Өндөрт ажил гүйцэтгэж байгаа үед ажлын байрны доод хэсэгт аюулгүй бүсийг гаргаж өгөх хэрэгтэй. Өндрийн нэг чиг шугамын дагууд (энэ бүлгийн 4.10-д тусгагдсанаас бусад тохиолдолд) хэд хэдэн ажлыг нэгэн зэрэг хийх тохиолдолд дээр нь байрлаж байгаа ажлын байрнаас 6 м-ээс ихгүй зайд доод талын ажлын байрыг (дэвсгэр банз, тор, саравч зэрэг) хамгаалалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байвал зохино.

6.2.22.20°-аас дээш налуутай дээвэр, түүнчлэн ажиллагчдын биеийн жинг тооцоогүй хучилттай дээвэр дээр ажил гүйцэтгэж байгаа ажилчдад зориулж хөл тулах хөндлөвчтэй, 0.3 м-ээс багагүй өргөн шат байрлуулах шаардлагатай. Ажил гүйцэтгэж байгаа үед шат нь хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байх ёстой.

6.2.23.Гаднаас удирдан ажиллуулах зориулалтын тоног төхөөрөмж ажиллаж байгааг сануулах дуут болон гэрлэн дохиололтой байх ёстой. Шаардлагатай тохиолдолд оператортой холбогдсон байна.

6.3.Материал бүтээц, хийц хэсгийн хадгалалт, агуулах аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага

6.3.1.Материалыг хадгалах, агуулах, тээврийн хэрэгслийн зам засах, цахилгаан, холбооны агаарын шугамын шон суулгах ажлыг бэхэлгээгүй ухсан хүнхээл, сувгийн хөрсний нуралтын налуугийн хязгаарын гадна гүйцэтгэх ба харин тэдгээрийг бэхэлсэн,

налалтын тогтворжилтыг бэхэлгээний шаардлагын дагуу урьдчилан шалгасан, динамик ачааллын тооцоогоор баталгаажуулсан нөхцөлд бэхэлгээтэйгээр ухсан хүнхээл, сувгийн хөрсний нуралтын налуугийн хязгаарт байрлуулахыг зөвшөөрнө.

6.3.2.Энэхүү норм дүрэм, MNS5079:2001 -ын шаардлагын дагуу агуулах, хадгалах материалыг өөрөө шилжих, суух, нурах, гулсах, өнхрөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, тэгшлэн зассан талбайд материалыг байрлуулбал зохино.

Материал агуулах талбай нь гадаргуугийн уснаас хамгаалагдсан байвал зохино.

Материал эдлэхүүнийг нягтруулаагүй хөрсөн дээр агуулах, хадгалахыг хориглоно.

6.3.3.Барилгын талбай, ажлын байранд материал, эдлэхүүн, бүтээц, хийц хэсэг, тоног төхөөрөмжийг дараах байдлаар хадгалж, байрлуулвал зохино.

- Улавч тавиур дээр багцлан өрсөн тоосгыг хоёроос илүүгүй үеэр давхарлан, чингэлэгтэй тоосгыг нэг үеэр, чингэлэггүй бол 1.7 м-ээс илүүгүй өндрөөр давхарлан хурааж агуулна.

- Суурь, зоорийн ханын гулдмайг дэр мод, ивүүр хэрэглэн 2.6 м-ээс илүүгүй өндрөөр давхарлан хурааж агуулна.

- Ханын хавтанг кассет буюу пирамид ашиглан налуулж, ташуулан хадгалах ба харин тасалгааны жижиг хавтанг кассетанд эгц босоо байдлаар агуулна.

- Ханын гулдмайг дэр мод, ивүүр хэрэглэн хоёр үеэр давхарлан хураана.

- Хучилтын хавтанг дэр ба ивүүр хэрэглэн 2.5 м-ээс илүүгүй өндөртэйгээр давхарлан хурааж хадгална.

- Дам нуруу, баганыг дэр, ивүүр хэрэглэн 2 м-ээс илүүгүй өндөртэйгээр давхарлан хураана.

- Гуалинг эгнээний хооронд дэр хэрэглэн 1.5 м-ээс илүүгүй өндөртэйгээр давхарлан хурааж агуулах ба өнхрөхөөс хамгаалсан ивүүр хэрэглэвэл зохино. Хураалгын өргөн нь өндрийн хэмжээнээс бага байхыг хориглоно.

- Зүсмэл материалыг ердийн эгнээгээр хурааж хадгалах нөхцөлд хураалгын өндөр нь өргөний хагасаас илүүгүй байвал зохино. Харин үүрлэн (торлон) хураах өндөр нь хураалгын өргөнөөс илүүгүй байвал зохино.

- Бага сортын ган цувималыг тавиур дээр 1.5 м-ээс илүүгүй өндөртэйгээр;

- Сантехник, агааржуулалтын гулдмайг дэр, хавчуурга ашиглан 2м-ээс илүүгүй өндөртэйгээр хурааж агуулна.

- Овор ихтэй, хүнд жинтэй тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийг дэр хэрэглэн нэг үеэр байрлуулна.

- Хайрцагтай шил, хуйлмал материалыг дэр хэрэглэн босоогоор нэг эгнээгээр;

- Хар төмөрлөгийн цувимал (гөлмөн төмөр, швеллер, двутавр, сортын ган)-ыг дэр, хавчуурга хэрэглэн 1.5 м хүртэл өндөртэйгээр давхарлан хураана.

- 300мм хүртэлх голчтой янданг дэр, төгсгөвчийн тулгуур хэрэглэн 3м хүртэл өндөртэйгээр давхарлан хураана.

- 300мм-ээс дээш голчтой янданг дэр, төгсгөвчийн тулгуургүйгээр 3м хүртэл өндөртэйгээр давхарлан хураана.

- Бусад материал, бүтээц, хийц хэсэг, эдлэхүүнийг тэдгээрийн стандарт, техникийн шаардлагад зааснаар хурааж хадгална.

6.3.4.Агуулахад хураасан материал (тавиурууд)-ын хооронд 1 м-ээс багагүй явах зай үлдээх ба тээврийн хэрэгсэл, ачих-буулгах механизмын овор хэмжээнээс хамааруулан явах замын өргөнийг тогтооно. Материал, бүтээц, эдлэхүүнийг хашаа, мод, барилга, түр байгууламжид налуулан байрлуулахыг хориглоно.

6.4.Цахилгааны аюулгүй байдлын хангалт

6.4.1.Цахилгаан тоноглолын ашиглалт, үйлчилгээг энэхүү дүрмийн хавсралт А-д заасан "Цахилгаан байгууламжийн дүрэм" (БД43-101-03), "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагын дагуу гүйцэтгэвэл зохино.

6.4.2.Үйлдвэрлэлийн талбайд цахилгааны байнгын ба түр сүлжээний техникийн үйлчилгээг, цахилгааны аюулгүй ажиллагааны зохих мэргэжлийн зэрэг бүхий цахилгаан техникийн ажилтнуудын хүчээр гүйцэтгэвэл зохино.

6.4.3.Барьж байгаа барилгын цахилгааны хангамжид ашиглагдах 1000В хүртлэх хүчдэлийн цахилгааны салбар түр сүлжээг тусгаарлалт бүрээс сайтай утас, эсхүл тулгуур дээгүүр дамнуулан байрлуулах буюу дамжуулах утас, кабелийн таталт, механик бат бэхийг тооцоолсон, газар, шалны түвшнээс дээш, дор зааснаас багагүй өндөрт байрлуулбал зохино:

- гарцын дээгүүр - 3.5 м;
- автомашины зам дээгүүр - 6.0 м;
- ажлын байрны дээгүүр - 2.5 м.

6.4.4.Ерөнхий гэрэлтүүлэгийн 127 ба 220 В хүчдлийн гэрэлтүүлэгчийг газар, шал, шат, вандангийн төвшнөөс 2.5 м-ээс багагүй өндөрт байрлуулвал зохино.

Гэрэлтүүлэгчийг 2.5 м-ээс бага өндөрт байрлуулах нөхцөлд тусгай хийцийн гэрэлтүүлэгч хэрэглэх, эсхүл 42 В-оос илүүгүй хүчдэл ашиглавал зохино. 42 В хүртэлх хүчдэлийн гэрэлтүүлэгчийг тогтмол гүйдлийн зай, машины хувьсгагч буюу бууруулагч трансформатороос тэжээхээр гүйцэтгэвэл зохино.

Дээр заасан зорилгод автотрансформатор, дроселль, хувьсгагч (реостат) хэрэглэхийг хориглоно.

Бууруулагч трансформаторын эх бие, хоёрдогч ороомог нь газардуулагдсан байх шаардлагатай.

Гар чийдэнг орлуулан суурин гэрэлтүүлэгч хэрэглэхийг хориглоно. Зөвхөн үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн зориулалтын гар чийдэн, гэрэлтүүлэгч хэрэглэвэл зохино.

6.4.5.Ил задгай буюу чийглэг орчинд ашиглах залгуур, унтраалга болон угсралтын бусад цахилгаан хэрэгсэл нь ГОСТ 14254-96 стандартын шаардлагын дагуу хамгаалалттайгаар хийгдсэн байх ёстой.

6.4.6.Цахилгааны залгуурын бүх тоног хэрэгслэлийг, гадны хүн тоног төхөөрөмжийг залгах, ажиллуулах боломжгүйгээр байрлуулбал зохино. Нэг залгах төхөөрөмжөөр хэд хэдэн гүйдэл хүлээн авагч залгахыг хориглоно.

Хуваарилах самбар, салгуурууд нь цоожтой, зориулалтын бусаар залгах, салгах боломжийг хязгаарласан байвал зохино.

6.4.7.Тасалгааны гадна, дотно ашиглах гар багаж, зөөврийн цахилгаан төхөөрөмжийн 20А хүртлэх гүйдлийн залгуур нь 30 мА -аас илүүгүй гүйдэл бүхий хамгаалалтын салгах төхөөрөмжөөр тоноглогдсон байх, эсхүл залгуур тус бүр нь 42В-оос илүүгүй хоёрдогч ороомгийн хүчдэлтэй хуваарилагч тусгаар трансформатороос тэжээгдэж байвал зохино.

6.4.8.42В хүртэлх хүчдэлийн сүлжээнд ашиглах залгуур, сэрээ нь 42В-оос илүү хүчдэлд ажиллах залгуур, сэрээний хийцээс бүтцийн хувьд ялгаатай байна.

6.4.9.Барилгын төмөр шат, ажлын байрны төмөр хайс, хашлага, кабель, дамжуулагч утасны тавиур, ховил, цахилгаан дамжуулга бүхий тээврийн хэрэгсэл, цамхагт өргөгчийн зам төмөр, тоног төхөөрөмжийн эх бие, цахилгаанаар ажиллах машин механизмууд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа норм дүрмийн дагуу шууд газардуулга хийгдсэн байвал зохино.

6.4.10.Цахилгаан тоноглолын гүйдэл хүлээн авагч хэсгүүд нь тусгаарлагдсан, хайс хашлагаар хашигдсан байх буюу тохиолдлоор тэдгээрт шүргэх, хүрэх боломжгүйгээр байрлуулсан байвал зохино.

6.4.11."Цахилгаан байгууламжийн дүрэм" (БД43-101-03)-ийн 1.7 ба 3 дугаар бүлгийн дагуу үйлдвэрлэлийн талбайн цахилгаан сүлжээ болон цахилгаан тоноглолыг цахилгаан гүйдлийн хэт өсөлтөөс хамгаалах хайлагч гал хамгаалагч буюу автомат салгуураар тоноглогдсон байвал зохино.

6.4.12.Ажиллаж байгаа цахилгаан тоноглол дээр ажил үүрэг гүйцэтгэж буй барилгын байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнууд нь албан томилолтоор ажиллаж байгаа

ажилтанд тооцогдоно.

Ажлын байрыг бэлтгэх, томилолтын ажилтанг ажилд оруулах асуудлыг ямар ч тохиолдолд ашиглагч талын цахилгаан техникийн ажилтан гүйцэтгэнэ.

6.5. Галын аюулгүй байдлын хангалт

6.5.1. Монгол Улсын галын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу үйлдвэрлэлийн талбай нь гал унтраах тоноглол, хэрэгслээр төхөөрөмжлөгдсөн байвал зохино.

6.5.2. Шатах, хурдан авалцах, галын аюултай материал агуулж байгаа байранд тамхи татахыг хориглох ба 50 м-ээс илүү зайд ил гал гаргах ба ашиглахыг зөвшөөрнө.

6.5.3. Талбайд шатахуун тосолгооны материал хадгалах (тостой алчуур, модны үртэс, зоргодос болон хуванцар хаягдал) —ыг хориглох ба харин тэдгээрийг аюулгүй байранд хаалттай төмөр чингэлэгт хадгалбал зохино.

6.5.4. Гал эсэргүүцэх тоног төхөөрөмжийг байнгын бүрэн бүтнээр, ажлын бэлэн байдалд байлгавал зохино. Гал эсэргүүцэх тоног төхөөрөмжид хүрэх зам, талбайг ямагт чөлөөтэй байлгахаас гадна зохих таних тэмдэг, заалт тавигдсан байвал зохино.

6.5.5. Цавуу, будаг, түрхлэг болон бусад материал бэлтгэх, хэрэглэх, тэсрэх аюултай, хортой бодис ялгаруулах ажлын байранд оч буюу ил гал гаргах, ашиглахыг хориглоно. Ийм ажлын байрыг салхилуулж, агаар солилцуулж байвал зохино. Ийм тасалгаа (бүс)-нд байрлах цахилгаан тоноглол нь тэсрэлтийн аюулгүй хамгаалалтын хийцтэй байвал зохино. Үүнээс гадна цахилгааны статик цэнэг хуримтлах боломжийг бүрэн хаах арга хэмжээ авсан байвал зохино.

6.5.6. Тэсрэх, галын аюултай ажлын байрыг гал унтраах анхан шатны болон болзошгүй аюулыг шуурхай мэдээлэх хяналтын хэрэгсэл, багаж тоноглолоор иж бүрэн хангаж, ажлын бэлэн байдалд байлгавал зохино.

6.6. Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл, нөлөөллөөс ажилтанг хамгаалах үйл ажиллагаа

6.6.1. Ажлын бүсийн агаарын найрлага дахь хортой бодисын агуулгын зөвшөөрөгдөх дээд хязгаар, мөн тэрчлэн ажлын байран дахь дуу чимээ, доргионы хэмжээ MNS 5002:2000, MNS 4990:2000, MNS 4994:2000 стандартуудаар тогтоогдсоноос илүү байх ёсгүй.

6.6.2. Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, тохирлын хяналтыг ажлын байрны хөдөлмөрийн нөхцлөөр хийгдэх норматив аттестатчиллын журмын дагуу гүйцэтгэвэл зохино.

6.6.3. Байгууллагын нутаг дэвсгэр дээр буюу үйлдвэрийн цех, тасагт барилга угсралтын ажил гүйцэтгэх нөхцөлд дагалдан үүсч болох хортой хүчин зүйлүүдийг тухайн байгууллагын хүрээнд тогтоосон журмын дагуу эрүүл ахуйн нормын биелэлтэд тавих хяналтыг нэгэн зэрэг зохион байгуулах шаардлагатай.

6.6.4. Хорт хий ялгарч болзошгүй орчин (үүний дотор битүү сав, худаг, суваг шуудуу, ухсан нүх г.м)-д ажил гүйцэтгэхийн өмнө 6.6.1 зүйлээр тавигдах шаардлагын дагуу орчны агаарын судалгааг хийх хэрэгтэй.

6.6.5. Хорт хий ялгарсан нөхцөлд тухайн байранд ажил гүйцэтгэхийг хориглон зогсоож, ажлын байрыг агааржуулалт (салхилуур) -аар хангах буюу ажиллагчдыг шаардлагатай нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан нөхцөлд ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Хий ялгарч болзошгүй байранд ажиллагчдыг хамгаалах хэрэгсэл (хорт хийн баг, өөрийгөө аврах хэрэгсэл) -ээр хангасан байвал зохино.

6.6.6. Битүү сав, худаг, ухсан нүхэнд ажил гүйцэтгэхдээ уян хоолой бүхий баг хэрэглэх бөгөөд ажил гүйцэтгэгчийг 2 ажилчин давхар хамгаалах зорилгоор хамгаалалтын бүснээс нь татуургаар бэхлэн худаг, битүү сав, ухсан нүхний гадна байрлаж, болзошгүй тохиолдолд татаж гаргах нөхцлийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байна.

6.6.7. Коллекторт ажил гүйцэтгэх үед ажиллагч нээлттэй хоёр худгийн голд байхаар тооцож, хамгийн ойрхон 2 худгийн тагийг заавал нээлттэй байлгана.

6.6.8.Ажиллах үедээ хортой хий, уур, тоос ялгаруулах тоног төхөөрөмж нь хортой ялгаруулалтын эх үүсвэрийг бүрэн хааж чадахуйц найдвартай бүтүүмжлэлийг хангах хаалт, хамгаалалтын хамт иж бүрнээр нийлүүлэгдэж байвал зохино. Хаалт хамгаалалтыг үйлдвэрийн хаягдлыг механикжсан аргаар зайлуулах тоос сорох системд холбох боломжтойгоор гүйцэтгэнэ.

6.6.9.Нийлэг материал, эдлэлийг ашиглахдаа тэдгээрийн паспорт, таних тэмдэг, савны гаднах бичилтийг удирдлага болговол зохино.

Импортын нийлэг материал, эдлэхүүнийг, тэдгээрийг хэрэглэх заавар, журам нь тогтоосон журмаар батлагдаж, Улсын Мэргэжлийн хяналтын газраас зөвшөөрсөн нөхцөлд хэрэглэнэ.

6.6.10.Тогтоосон журмын дагуу батлагдсан заавартай танилцахгүйгээр тэсрэх аюул, хортой шинж чанартай нийлэг материал, эдлэхүүнийг ашиглахыг хориглоно.

6.6.11.Будаг, маажин, тусгаарлах, засал чимэглэлийн болон бусад тэсрэх аюултай, хортой бодис ялгаруулах материалыг ажлын байранд нэг ээлжийн хэрэгцээнээс илүүгүй хэмжээгээр хадгалахыг зөвшөөрнө.

6.6.12.Хортой, тэсрэх аюултай уусгагч агуулсан материалыг битүүмжлэл бүхий таглаатай саванд хадгалбал*зохино.

6.6.13.Ажиллах явцдаа дуу чимээ үүсгэдэг машин, тэдгээрийн эд ангиудыг MNS 5002:2000 стандартад нийцүүлэн нормчлон тогтоосон зөвшөөрөгдөх шуугианы даралт, дууны түвшинээс илүүгүй байхаар ашиглавал зохино.

6.6.14.Машин, үйлдвэрийн барилга, байгууламжийг ашиглах, тэрчлэн ажлын байрыг зохион байгуулахдаа ажиллагчдад үзүүлэх хортой нөлөөлөл болон дууны хэт ихэссэн түвшинг бууруулах, арилгах дараах аргуудыг хэрэглэвэл зохино. Үүнд:

- Техникийн хэрэгсэл (машины дуу үүсгэгч эх үүсвэрийн дууг багасгах; ажлын байранд дууны даралтын төвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс илүүгүй байх технологи арга ажиллагааг хэрэглэх г.м)

- Барилгын норм ба дүрмийн дагуу дуу авианы хэмжээг тогтоосон түвшинд барих арга хэмжээг авах;

- Дуу чимээ ихтэй машиныг алсаас удирдах, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

- Зохион байгуулалтын арга хэмжээ (хөдөлмөр, амралтын дэглэмийг оновчтой сонгох, дуу чимээтэй нөхцөлд байх хугацааг богиносгох, эмчилгээ, сувилгаа болон бусад арга хэмжээ) авах.

6.6.15.Дууны төвшин 85 дБ -ээс дээш байх ажлын бүсэд аюулгүйн таних тэмдэг тавьж, ялгаварлан тогтоосон байх ёстой. Эдгээр бүсэд нэг бүрийн хамгаалах хэрэгсэлгүйгээр ажиллахыг хориглоно.

6.6.16.Дууны даралтын төвшин өндөр, 135 дБ-ээс дээш байгаа бүсэд богино хугацаагаар ч болов байхыг хориглоно.

6.6.17.Доргион чичиргээ үүсгэгч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь MNS4994:2000 стандартын шаардлагыг хангасан байвал зохино.

6.6.18.Доргион чичиргээнээс ажиллагсдад үзүүлэх хортой нөлөөллийг арилгахын тулд дараах арга хэмжээг авбал зохино. Үүнд:

- Хийц, бүтээцийн болон технологийн арга хэмжээгээр доргион чичиргээ болон түүнийг үүсгэгч, эх үүсвэрийг бууруулах;

- Доргион чичиргээ тархах замд тусгаарлах, шингээх хэрэгслэлүүд тавьж багасгах;

- Ажлын байранд доргилтын долгион дамжих нөхцлийг арилгах алсын удирдлага нэвтрүүлэх;

- Нэг бүрийн хамгаалах хэрэгслэлээр хангах.

6.6.19.Үйлдвэрлэлийн байр болон байнгын ажлын байранд техникийн хэрэгслэлээр доргионы хэмжээг эрүүл ахуйн нормын түвшинд хүргэн бууруулах боломжгүй тохиолдолд орон нутгийн эрүүл ахуйн хяналтын албатай зөвшөөрөлцсөний үндсэн дээр хөдөлмөрийн зохистой түр дэглэм боловсруулан хэрэгжүүлвэл зохино.

6.6.20.Тоос ялгаруулалт үүсдэг үйлдвэрийн байр, өрөө, тасалгааны хана, тааз, шалны

гадаргуу нь өөгүй тэгш, толигор байх шаардлагатай ба тоосыг тогтмол цэвэрлэж байвал зохино. Үйлдвэрлэлийн болон ажлын байрны тоосыг байгууллагын даргын тушаалаар заагдсан хугацаанд, тоос зайлуулах төв систем, зөөврийн тоос цэвэрлэх машин, мөн тоосжилт дахин үүсэхээс хамгаалсан аргуудаар цэвэрлэнэ.

6.6.21. Байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд барилга, байгууламжийн дээвэр дээр тоос хуримтлах үйл явцыг байнгын хяналтад авч, тухай бүрд нь аюулгүй байдлаар цэвэрлэж, зайлуулах арга хэмжээг зохион байгуулж байвал зохино.

6.6.22. Үйлдвэрлэлийн байрны өрөө тасалгааны бичил уур амьсгал нь эрүүл ахуйн норм ба дүрэм, СанПин 2.2.4.548-96-ын шаардлагыг хангаж байвал зохино.

6.6.23. Байнгын тоосорхог материалтай харьцах өрөө, тасалгаа, тэрчлэн тэдгээр материалыг бутлах, нунтаглах, тээрэмдэх болон шигших машины дэргэдэх ажлын байрууд нь тоос соруулах, агааржуулах, салхижуулах системээр хангагдсан байвал зохино.

Шохой, цемент, гөлтгөнө болон бусад тоосролт үүсгэгч материал боловсруулах төхөөрөмжийн механизм, тэжээгүүр, хаалтуудын удирдлагыг тусгаар байршилтай төвөөс гүйцэтгэхээр зохион байгуулвал зохино.

6.6.24. Тасалгааны шал нь үйлдвэрлэлийн явцад зөвшөөрөгдөх хэмжээний механик, дулаан болон химийн үйлчилгээнд тэсвэртэй, тогтвортой байвал зохино.

6.6.25. Өрөө, тасалгааны шалан дээгүүр байнга буюу үе үе шингэн (ус, хүчил, шүлт, органик уусгагч, эрдэс тос, эмульс, хүчил, шүлт буюу саармаг уусмал г.м) урсах шаардлагатай нөхцөлд шал нь эдгээр шингэнийг үл шингээхээс гадна, шингэн урсах тодорхой налуутай, ховилоор болон тусгай сувгаар урсах боломжтойгоор хийгдсэн байвал зохино.

Шалны болон урсах ховил, сувгийн налуугийн хэмжээ (хувиар) дор заасантай тэнцүү байвал зохино. Үүнд:

- дүнз, тоосго, бүх төрлийн бетон бүрхүүлтэй бол - 2-4 %;
- хавтанцар бүрхүүлтэй бол -1,2 %;
- үйлдвэрлэлийн хатуу хаягдлыг даралттай усаар угааж зайлуулах нөхцөлд -3-5 % байна.

Шингэнийг зайлуулах трап болон суваг нь шалны түвшинд таглаатай буюу торон хаалттай байвал зохино. Ус зайлуулах суваг нь явган болон тээврийн хэрэгслийн зорчих хэсгээс зайдуу, тэдгээртэй үл огтлолцох байдалд байрласан байх ёстой. Гадаргуугийн ус зайлуулах төхөөрөг (ховил, суваг, трап ба тэдгээрийн торон хаалт)-ийг цаг тухай бүрд нь цэвэрлэж байх ба засварлах шаардлагатай. Тайлбар: Энэ зүйлээр тавигдах шаардлага нь усаар цэвэрлэгддэг шал бүхий өрөө тасалгаанд нэгэн адилаар хамаарна.

6.6.26. Шалны бүтцийн эд ангиуд нь үйлдвэрлэлийн явцад шаланд хүрсэн хортой бодисыг шингээх буюу цуглуулахгүй байвал зохино. Шалны бүрхүүл нь үйлдвэрлэлийн бохирдол, тоос болон хортой бодисыг цэвэрлэхэд хялбар байх шаардлагыг хангасан байвал зохино.

7.Барилгын машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, механикжуулалтын хэрэгсэл, тоноглол, гар удирдлагатай машин багаж хэрэгслийн ашиглалт

7.1.Ерөнхий шаардлага

7.1.1. Барилгын машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж (хөдөлгөөнт ба суурин машин), механикжуулалтын хэрэгсэл, багаж, тоноглол (будаг, шавардлагын машин, дүүжин шат, шилжүүлэн угсрах шат, домкрат, ачааны чангалуур, цахилгаан өргүүр ба бусад), цахилгаан, хийн, гар багаж (цахилгаан өрөм, хөрөө, харуул, хадагч-тавлагч, хийн лантуу, лантуу г.м)-ууд нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдох стандартын шаардлагыг хангаж байх шаардлагатай. Харин тэдгээр нь дахин хэрэглэгдэж байгаа бол хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэх эсэхийг баталсан гэрчилгээтэй байвал зохино.

Дээр нэр заасан механикжуулалтын хэрэгслийг тэдгээрийн хаалт, хамгаалалт бүтээц, цахилгаан хамгаалалтын болон дохиоллын систем, бусад ажиллагсадын нийтийн хамгаалалтын хэрэгсэлгүйгээр ашиглахыг хориглоно.

7.1.2.Барилгын машиныг ГОСТ 12.3.033-84 стандартын шаардлагын дагуу ашиглавал зохино.

Ачаа өргөх машин ба бусад механикжуулалтын хэрэгслийн ашиглалтыг Улсын мэргэжлийн хяналтын газар, түүний баталсан норматив баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэвэл зохино.

7.1.3.Шинээр авсан, гэрээгээр авч ажиллуулсан буюу мэргэжлийн байгууллагын хяналтад үл хамаарах байгууллагаар их засвар хийлгэсэн машин, төхөөрөмжийг, ашиглалтыг хариуцагчаар туршилт хийлгэсэн тохиолдолд ашиглахыг зөвшөөрнө.

7.1.4.Машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг зориулалтын нь дагуу, үйлдвэрлэгч-заводоос тогтоосон нөхцөлд ашиглахыг зөвшөөрнө.

7.1.5.Машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ба бусад механикжуулалтын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг өөрийн хүчээр буюу төрөлжсөн мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийлгэж байвал зохино. Машин төхөөрөмж ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэл, саатлын жагсаалтыг тухайн үйлдвэрлэгч-заводын баримт бичгээр тогтооно.

7.1.6.Машин, тээврийн хэрэгсэл ба бусад механикжуулалтын хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээг зөвхөн тэдгээрийг зогсоож, хөдөлгүүр (дамжуулагч)-ийг унтраан, тохиолдлоор хөдөлгүүр асах, машин өнхрөх ба түүний эд ангиуд нь хөдөлгөөнд орох боломжийг бүрэн арилгаж, шингэн ба хийн шахуургын системийн даралтыг бүрэн бууруулсны дараа буюу ашиглалт, засварын баримт бичгээр зөвшөөрөгдсөн бусад тохиолдолд гүйцэтгэвэл зохино.

7.1.7.Техникийн үйлчилгээ, засварын үед машин, тээврийн хэрэгслийн, өөрийн жингийн үйлчлэлээр шилжих боломж бүхий угсралтын нэгжийг механик аргаар үл хөдлөх бэхэлгээ хийх буюу өөрөө шилжих боломжийг хаах тулгуур дээр суурилуулвал зохино.

7.1.8.Цахилгаан хөтлөгч бүхий машины техникийн үйлчилгээний үед цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу тохиолдлоор хүчдэл өгөгдөх, залгагдах боломжийг гаргахгүй байх арга хэмжээг авсан байвал зохино.

7.1.9.Тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, механикжуулалтын бусад хэрэгслийн урсгал засвар, техникийн үйлчилгээний үед ажлын байр нь найдвартай ажиллагаа бүхий иж бүрэн багаж, хэрэгсэл, тоноглол, ачаа өргөх ба гал унтраах хэрэгслээр тоноглогдсон байвал зохино.

7.1.10.Хараа хяналтгүйгээр машин, тээврийн хэрэгсэл, механикжуулалтын багаж хэрэгслийг хүчдэлд залгаатай, ажиллаж байгаа байдлаар орхихыг хориглоно.

7.1.11.Машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, механикжуулалтын бусад хэрэгслүүдийг залгах, ажиллуулах үйл ажиллагааг зөвхөн эдгээр хэрэгслийг удирдах, хариуцан ажиллуулахаар томилогдсон үнэмлэх бүхий этгээд гүйцэтгэнэ.

7.1.12.Ашиглалтын баримт бичгээр тоноглогдсон нөхцөлд машин, тээврийн хэрэгслийг ашиглах үед дуу чимээ, доргион, тоосролт, утааны түвшин машинч (жолооч)-ийн ажлын байр болон машины ажлын бүсэд нормоор тогтоосон хэмжээнээс илүүгүй, харин гэрэлтүүлгийн түвшин нормоор тогтоосон доод хэмжээнээс багагүй байвал зохино.

7.1.13.Механикжуулалтын хэрэгслийг угсрах (буулгах, задлах) үйл ажиллагааг үйлдвэрлэгч-заводын зааврын дагуу угсарч, холбогдох албан тушаалтны удирдлагын дор, мэргэжилтэй ажилчид гүйцэтгэнэ.

7.1.14.Угсралтын бүс нь хайс, хашлагаар хязгаарлагдсан байхаас гадна аюулгүйн тэмдэг, урьдчилан сануулах дохио, тэмдгүүдээр хангагдсан байна.

Машины паспортод заасан хэмжээнээс илүү хурдтай салхи, агаарын хэт халалт, хөрөлт, аадар бороо, цасан шуурга, манан, мөстлөгийн үед задгай орчинд машины угсралт (буулгах, задлах)-ын ажил гүйцэтгэхийг хориглоно.

7.2.Бага оврын машин ба тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага

7.2.1.Бага оврын машиныг үйлдвэрлэлийн талбайд байрлуулахдаа ажлыг удирдан гүйцэтгэгч албан тушаалтан, ажил эхлэхийн өмнө машины ажлын болон түүний үүсгэж болох аюултай бүсийг тодорхойлон тогтоосон байх ёстой.

Машинчийн ажлын байрнаас ажлын бүс бүрэн харагдах орчинг хангасан байвал зохино. Хэрэв машинчид үзэгдэх орчин бүрэн хангагдаагүй тохиолдолд түүнд дохиочинг заавал гаргаж өгч ажиллуулах ёстой.

Машины хөдөлгөөн ба ажил гүйцэтгэх явцад өгөгдөх дохионы утга, агуулга болон заалтуудыг тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүх хүмүүст танилцуулсан байна. Машины ажлын явцад үүсэх буюу үүсч болох аюултай бүсийг аюулгүйн тэмдэг болон урьдчилан сануулах тэмдгээр тусгайлан хангасан байвал зохино.

7.2.2.Ашиглагдаж байгаа бүх төрөл, марк, зориулалтын автомашины тусгай зориулалтын тоног төхөөрөмж нь автотээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаж байвал зохино. Замын цагдаагийн газар, Автотээврийн газар, тээврийн хяналтын бусад газраас зохион байгуулдаг техникийн улсын үзлэг, тооллого явуулах журмын дагуу жил бүр техникийн үзлэгт хамрагдсан байна.

7.2.3.Машин, тээврийн хэрэгслийг байрлуулах, ашиглах үед салхины үйлчлэлээр туугдаж шилжих, тухайн газрын хөрсний суулт, налалтаас болж онхолдох аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байвал зохино.

7.2.4.Машин, тээврийн хэрэгслийг бэхэлгээгүй налуу ухсан (хүнхээл, суваг, шуудуу г.м) нүхний ойролцоох орчинд шилжүүлэх, байрлуулах, ажиллуулахдаа зөвхөн хөрсний нуралтын налуугийн зохион байгуулалт-технологийн баримт бичгээр тогтоосон зайд байрлуулж, шилжүүлэх буюу ажиллуулахыг зөвшөөрнө.

Ажил гүйцэтгэх төсөлд холбогдох заалт байхгүй нөхцөлд хэвтээ чиглэлд ухдасын налалтын сууриас машины хамгийн ойрын тулгуур хүртлэх зайг хүснэгт 1-т зааснаар авч, хэрэглэхийг зөвшөөрнө.

Хүснэгт 1.

Ухаадсын гүн, м	Хөрс			
	Элсэрхэг	Элсэнцэр	Шавранцар	Шаварлаг
	Ухаадсын налалтын сууриас, машин хүртлэх хэвтээ зай, м чиглэл дагуух			
1,0	1,5	1,25	1,0	1,0
2,0	3,0	2,4	2,0	1,5
3,0	4,0	3,6	3,25	1,75
4,0	5,0	4,4	4,0	3,0
5,0	6,0	5,3	4,75	3,5

7.2.5.Ашиглалтад байгаа цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүсэд машин ашиглан гүйцэтгэх барилга угсралтын ажлыг 4.12 зүйлээр тавигдах шаардлагын дагуу тухайн шугамыг ашиглагч байгууллагын бичгээр өгөгдсөн ажил гүйцэтгэх аюулгүйн нөхцлийг тодорхойлон заасан зөвшөөрлийн үндсэн дээр аюулгүй байдлын дараах арга хэмжээг хангасан тохиолдолд, ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааг хариуцсан албан тушаалтны шууд удирдлагын дор гүйцэтгэвэл зохино.

7.2.5.1.Барилгын машиныг байрлуулах ба өргөгддөг тэвш бүхий тээврийн хэрэгслийг цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын бүсэд ажиллуулахад тухайн шугамыг хүчдлээс салгасан байх шаардлагатай.

7.2.5.2.Цахилгаан дамжуулах агаарын шугамыг хүчдлээс тодорхой үндэслэлээр салгах боломжгүй бол цахилгааны шугамын хамгаалалтын бүсэд дор дурдсан

шаардлагуудыг хангасан нөхцөлд барилгын машиныг ажиллуулахыг зөвшөөрнө.

А)Барилгын машины өргөх буюу хөдөлгөөнт хэсгийн ямар ч байрлалаас хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам хүртлэх зай ГОСТ12.1.051-90 стандартын дагуу хүснэгт 2-т зааснаас багагүй байх ёстой.

Б)Гинжит өөр явагч механизмаас бусад машины эх биеийг зөөврийн газардуулагчаар газардуулга хийсэн байвал зохино.

Хүснэгт 2.

Агаарын шугамын хүчдэл, кВ	Зай, м	
	Хамгийн бага	Техникийн хэрэгслээр хэмжигдэх хамгийн бага
20 хүртэл	2,0	2,0
20-35 -аас дээш	2,0	2,0
35-110 -аас дээш	3,0	4,0
110-220-оосдээш	4,0	5,0
220-400 -аас дээш	5,0	7,0
400-750 -иас дээш	9,0	10,0
750-1150 -иас дээш	10,0	11,0

7.2.5.3.Өөрөө явагч сумт краныг цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүсэд байрлуулахдаа сумаа өргөхийн өмнө дэгээ, тэнжээг салгах үйл ажиллагааг оосорлогчийн оролцоогүй, краны машинч өөрөө гүйцэтгэнэ.

7.2.6.Машины засвар, техникийн үйлчилгээг ажлын бүсийн гадна хийнэ.

7.2.7.Онцгой нөхцөлд (ухсан хөрсөнд налуу гаргаж тэгшлэх, өндөр хүчдэлийн шугам буюу ашиглагдаж байгаа барилга байгууламжийн ойролцоох хөрсөөр булагдсан хэсгийг цэвэрлэх) машинаар ажил гүйцэтгэх үед ажиллагсад, бусад хүмүүсийг машины ажлын явцад үүсч болох үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлээс урьдчилан сэргийлэхүйц, нэмэгдэл хэрэгслээр машиныг тоноглогсон байвал зохино.

7.2.8.Машин, тээврийн хэрэгслийг тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл дээр буюу хөлөөр нь зориулалтын замаар тээвэрлэн шилжүүлэхэд замын хөдөлгөөний дүрмийг баримтална.

Машин, тээврийн хэрэгслийг байгалийн бартаа, зохиомол байгууламж болон төмөр замын хаалтгүй гармаар дамжуулан тээвэрлэхдээ замын хөдөлгөөний байдлыг судалсны үндсэн дээр гүйцэтгэвэл зохино. Шаардлагатай тохиолдолд машин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний замыг тухайн машин, тээврийн хэрэгслийн ашиглалтын баримт бичигт заасан шаардлагын дагуу замыг тэгшлэх буюу бэхэлсэн байвал зохино.

7.2.9.Хөдөлгөөнт тоноглол бүхий машин ашиглах үед ажлын аюултай бүсэд хүмүүс орохоос урьдчилан сэргийлж, хэрвээ үйлдвэрлэгч-заводын зааварт өөр нэмэгдэл шаардлага тавиагүй бол машин төхөөрөмжөөс 5м-ээс багагүй зайд аюултай бүсийн хилийн зайг тогтооно.

7.2.10.Цахилгаан тэргэнцэрийн гүйдэл хүлээн авагч, удирдлага, тормоз (хурд сааруулагч) ба дохио бүрэн бус, тэрчлэн цахилгаан гүйдлийн үйлчлэлээс хамгаалах (тусгаарлах дэвсгэр, тусгаарлагч бээлий) хэрэгсэлгүйгээр ашиглахыг хориглоно.

7.3.Суурь машины ашиглалтын үеийн аюулгүйн ажиллагаанд тавигдах шаардлага

7.3.1.Үйлдвэр, объектын өргөтгөл, техникийн шинэчлэлт, сэргээн засварлалт, суурилагдсан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж (суурин машин)-ийг хүлээн авах объектын бүрэлдэхүүнд хамруулан тогтоосон журмын дагуу ашиглалтад оруулна.

Барилгын талбайд суурилагдсан машин, тоног төхөөрөмж (бетон-зуурмагийн үзел, завод, өргөгч, шахсан хийн станцууд г.м) -ийг мөн талбай дээр тухайн төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан албан

тушаалтан, шаардлагатай тохиолдолд улсын холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын оролцоотой, хамтын шийдвэрээр ашиглалтад оруулах ба хүлээн авна. 7.3.2.Үйлдвэрийн нутаг дэвсгэр дээр суурин ажиллагаатай машин төхөөрөмжийг зураг төслийн дагуу байрлуулах ба үүнд цехүүдэд байвал зохих зай хэмжээ дор дурдсанаас багагүй байвал зохино.

- Төв хэсгийн зай 1,5 м

- Тоног төхөөрөмж хоорондын зай 1,2 м

- Үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж хоорондын зай 1,0 м

- Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээнд зориулагдсан зай 0,7 м.

Ажлын байрны явах хэсгийн нэг талд байрлалтай нөхцөлд ажлын байрны дэргэдэх явах хэсгийн өргөнийг 0,75 м —ээс багагүй, харин хоёр талын байрлалтай явах хэсгийн өргөнийг 1,5 м-ээс багагүйгээр нэмэгдүүлвэл зохино.

7.3.3.Ажиллах явцдаа тоос үүсгэдэг суурин машин (бутлах, нунтаглах, холигч г.м)

-ууд нь тоос шүүх болон зайлуулах хэрэгслээр тоноглогдсон байвал зохино.

7.3.4.Аюул учруулж болзошгүй суурин төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгүүдийг тор буюу хаалт, хашлагаар хамгаалсан байвал зохино.

7.3.5.Бүтэц болон технологийн шаардлагаар хаалт хамгаалалтыг суурин байдлаар тоноглох боломжгүй нөхцөлд салгаж, угсардаг хаалт хамгаалалт, хэрэглэхийг зөвшөөрнө.

7.3.6.Хаалт хамгаалалт буюу тоног төхөөрөмжийн эх биен дэх салгаж, угсардаг, гүйдэг таг, хаалга, цонх зэргийг тохиолдлоор салж, нээгдэх боломжийг хязгаарласан автомат түгжээгээр тоноглогдсон байх хэрэгтэй.

7.3.7.Машины ашиглалтын үед цахилгаан гүйдэлд цохиулахаас хамгаалах дор дурдсан аюулгүйн арга хэмжээг хэрэглэвэл зохино. Үүнд:

- Аюул учруулах үүсвэр болох үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн гүйдэл дамжуулагч хэсгүүд нь найдвартай тусгаарлалттай байхаас гадна, хаалт хамгаалалтайн дээр хүн хүрэхээргүй орчинд тусгайлан байрласан байвал зохино.

- Цахилгаан төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсгүүд нь цоож цуургаар тоноглогдсон бат бэх хаалга бүхий өрөө тасалгаа, хайс хашлаганд байрлавал зохих ба хүн хүрэх боломжтой газар байрлалтай бол хамгаалах хашлагаар битүүлэн хаасан байна.

- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн төмөрлөг эд ангиуд, тусгаарлалт гэмтсэний улмаас аюултайд тооцогдох хэмжээний хүчдэл дамжигдахад хүрч болох тул төмөрлөг эд ангиудыг газардуулсан байвал зохино.

- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн цахилгааны холболтын схемд цахилгааны бүхий л хэлхээсийг тэжээлийн шугамаас төвлөрүүлэн салгах төхөөрөмж байрлуулахаар төлөвлөсөн байвал зохино.

7.3.8.Нэгээс илүү тооны ажиллагчид бүхий технологийн нэгдмэл үйл явцад нэгтгэгдсэн машинууд нь ажилчдад машиныг ажиллуулах тухай урьдчилан сэргийлэх дохиоллын системээр хангагдсан байвал зохино.

Алсаас төхөөрөмжийг залгаж, хөдөлгөхдөө урьдчилаа сануулах дуут болон гэрлэн дохио өгч, тоног төхөөрөмжийн үйлчилгээний байрнаас залгаж болох тухай хариу дохио хүлээж авсны дараа залгана.

7.3.9.Дохионы хэрэгсэл (хонх, гэрэл, дуут дохио)-үүд нь механик гэмтлээс хамгаалагдсан, үйлчилгээний ажилчдын ажлын бүсэд найдвартай сонсогдох ба үзэгдэх орчинд байрласан байвал зохино.

7.3.10.Дохиоллын хүснэгт, тоног төхөөрөмжийг залгах ба салгах дарааллын тухай журмыг ажлын байр, цехүүдэд ил тод харагдах газар байрлуулвал зохино.

7.3.11.Үйлдвэрийн байр, галерей, эстакадад туузан болон бусад төрлийн зөөүүрүүдийг байрлуулах ба тэдгээрийн бүтээц нь ГОСТ 12.2.022-80 стандартын аюулгүйн шаардлагыг хангасан байна.

7.3.12.Тоосрох материал тээвэрлэхэд зориулагдсан босоо шанаган, хусуурт ба шурган зөөгүүрүүдийг бүхий л уртад тоос ялгарах боломжийг арилгаж чадахуйц

бүрхүүл, хаалтаар тоноглогдсон байвал зохино.

7.3.13.Бункер-хуримтлуулагч нь үйлчилгээний талбайгаар тоноглогдсон байх ба дор дурдсан хэмжээтэй байвал зохино.

- Шал буюу хучилтаас тасалгааны бүтээц хүртлэх өндөр 2,0 м-ээс багагүй;

- өргөн 1,0 м-ээс багагүй;

- талбайн эргэн тойрны хашлагын өндөр 1,1 м-ээс багагүй;

7.3.14.Бункерийн хяналтын цонх нь цоож, түгжээ бүхий нээгддэг тагтай байвал зохино. Түлхүүрийг ажлыг удирдагч хадгална.

Бункерд материал наалдаж овоорохоос урьдчилан сэргийлэх төхөөрөг (цахилгаан доргиур, уур-цахилгаан халаагуур, хийн үлээгүүр г.м) хэрэглэвэл зохино.

Бункерүүдийг 20х20 см-ээс илүүгүй нүх бүхий тороор хаасан байх шаардлагатай. Бункерийн цэвэрлэгээг хариуцлагатай албан тушаалтны хяналтын дор гүйцэтгэвэл зохино.

Том ширхэглэлийн материалыг гар багажаар бункерийн торон дээр цохиж, бутлахыг хориглоно. Бутлуурыг ажиллаж байх үед камераас материалын бөөн хэсгүүдийг авахыг хориглоно.

7.3.15.Бөмбөлөгт тээрэм ба бутлуур нь хүлээн авах, тээврийн тоноглолын үйлчилгээний талбай, төв удирдлагатай холбосон хоёр талын дохиоллын холбоог хангасан дуут ба гэрлэн дохионы системээр тоноглогдсон байх ёстой.

7.3.16.Бөмбөлөгт төрлийн барабаныг хүмүүс зорчих талаас торон хашлага хийж хамгаалсан байвал зохино. Хамгаалалтын торон хашлагын хаалгыг нээхэд хүчдэл шууд салж байхаар автомат унтраалгаар тоноглогдсон байвал зохино.

7.3.17.Хүлээн авах цоргууд нь салгаж, угсардаг төмөр хашлагатай байна.

7.3.18.Бутлуурын үйлчлэгч ажилтан (машинч) бутлуурын камерт тохиолдлоор орсон, үл бутлагдах биетийг гаргаж авахад шаардлагатай тоног хэрэгсэл (дэгээ, хавчаар г.м) болон хамгаалалтын нүдний шилээр хангагдсан байх ёстой.

7.3.19.Ачаа ачих, буулгах талбайд өргөгч цамхаг ашиглах үед, ачаа ачих, буулгах арга, дохиоллын арга хэлбэр, дохиочин-оосорлогчийн үйл ажиллагааны журам, барилгын ачаа өргөгчийн тавцанд хүн гарахыг хориглох болон өргөгч-цамхагийн үйлчилгээний бусад зааврыг багтаасан, үйлчилгээний зааврыг өргөгч цамхагийн кабин (тавцан) -д зүүж байрлуулсан байвал зохино.

7.3.20.Өргөгч- цамхагийн задгай тавцангийн ачаалах байрны дээр 2,5-5 м өндөрт, 40мм-ээс багагүй зузаан банзаар хамгаалалтын давхар шал суулгасан байвал зохино.

7.3.21.0,07 МПа -аас илүү даралтат сав, 115°С-аас илүү температур бүхий ус халаах тогоо суурилуулах, ашиглалт, засварын аюулгүй ажиллагааны зохион байгуулалт нь энэхүү дүрмийн хавсралт А-д заасан "Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Уурын ба усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн шаардлагыг хангаж байвал зохино.

7.3.22.0,07 МПа-аас илүүгүй даралтад ажиллах уурын тогоо, 115°С (388 К)-аас илүүгүй температур бүхий ус халаагч, халаалтын усан тогооны угсралт, засвар үйлчилгээ ба ашиглалтыг энэхүү дүрмийн хавсралт А-д заасан "Уур, халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн шаардлагын дагуу гүйцэтгэвэл зохино.

7.3.23.Энэ дүрмийн 7.3.21, 7.3.22 зүйлд заасан тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага савны ашиглалт, техникийн байдалд хяналт тавих үүрэг бүхий ажилтан, тоног төхөөрөмжийн бүрэн байдал, аюулгүй ажиллагаа эрхэлсэн албан тушаалтныг мэдлэгийн шалгалтад тогтоосон журмын дагуу хамрагдсан үйлдвэрийн мэргэжилтнүүдээс томилон ажиллуулвал зохино.

7.3.24.Рельсэн краны замын ашиглалт, байгууламж нь ГОСТ Р 51248-99 стандартын шаардлагыг хангасан байх ёстой.

7.4.Механикжуулалтын хэрэгсэл, дамжуур шат, тоноглол, цахилгаанжсан

багажны ашиглалтын үеийн аюулгүйн шаардлага

7.4.1.Механикжуулалтын хэрэгсэл, тоноглол, төхөөрөмж, цахилгаанжсан гар багаж, машиныг ажиллуулагч ажилтан, үйлдвэрлэгч-заводын болон зааврын дагуу тэдгээрийг хэрэглэн ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны арга барилын сургалтад хамрагдсан байвал зохино.

7.4.2.Дүүжин шатыг өргөхөд зориулагдсан газар дээр суурилуулан лебедкийг түүний татах хүчээс 2 дахинаас илүү жинтэй хүндрүүлэх ачаагаар ачаалбал зохино. Хүндрүүлэх ачааг лебедкийн арал дээр бэхэлнэ. Лебедкийн гол дээр ороогдох татлагын ороодсын тоо ачааны доод байрлалд, хоёроос цөөнгүй байх ёстой.

7.4.3.Ачаа өргөх домкратыг ашиглаж эхлэхийн өмнө, мөн 12 сар тутамд, тэрчлэн нэг бригадаас нөгөөд шилжүүлэх ба засварын дараа заавал туршиж байвал зохино.

Туршилтыг даацаас 25 хувиар илүү статик ачаагаар гүйцэтгэвэл зохино. Туршихдаа ашиглалтын баримт бичгийн дагуу домкратын шураг, толгойг ачааг хамгийн өндөрт өргөхөд дүйцэх, эцсийн дээд байдалд хүргэн сунгасан байх ёстой.

7.4.4.Ачаа оосорлох хэрэгсэл, кассет, сав боодол зэрэг тоноглолуудыг тэдгээрийн ашиглалт, бүрэн байдлыг хариуцагч албан тушаалтан эрхлэн ашиглалтын явцад ачаа өргөх кран болон бусад технологийн тоног хэрэгслийн аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагаар тогтоогдсон хугацаанд техникийн үзлэгт хамруулж байвал зохино. Техникийн нөхцөл, үйлдвэрлэгч-заводын зааварт өөрөөр заагдаагүй бол 6 сар тутам нэгээс цөөнгүй удаа үзлэг хийх ба үзлэгийн дүнг ажлын журналд бүртгэж байна. Үзлэгт хамрагдаагүй ачаа оосорлох хэрэгсэл, кассет, сав баглаа боодлыг хэрэглэхийг хориглоно.

7.4.5.Барилгын материалын үйлдвэр, барилгын бусад үйлдвэрлэлд ашиглаж байгаа ачаа өргөх дэгээ, тоноглол (тэнжээ, траверс) нь өргөж байгаа ачаа мултрахаас урьдчилан сэргийлэх түгжих төхөөрөмжөөр хангагдсан байх шаардлагатай.

7.4.6.Барилгын шат угсрах хөрсний гадаргууг тэгшилж, нягтруулсан байхаас гадна гадаргуугийн усыг зайлуулахаар тооцоологдсон байвал зохино. Эдгээр шаардлагыг хангах боломжгүй тохиолдолд шат, хайсыг тохируулга хийх боломжтой тулгуур (домкрат) хэрэглэн хэвтээ чиглэлийн тэгш байдлыг хангах буюу түр тулгуур байгууламж хэрэглэвэл зохино.

7.4.7.Барилгын шат нь тооцооны хувийн тогтворжилтыг хангахгүй нөхцөлд барилгын хананд (угсармал шат) үйлдвэрлэгч - заводын техникийн баримт бичигт заагдсан аргуудаар бэхлэх буюу ажил гүйцэтгэх зохион байгуулалт-технологийн баримт бичгүүдэд тусгагдсаны дагуу гүйцэтгэвэл зохино.

Бэхэлгээний байршил, арга хэлбэрүүд зохион байгуулалт-технологийн баримт бичигт заагдсан байвал зохино. Төсөл болон үйлдвэрлэгч- заводын зааварт тусгайлсан заалт ороогүй бол шатны барилгын хананд хийгдэх бэхэлгээг захын багананд нэг эгнээ алгасан, дээд эгнээнд 2 алслалын дараа ба шатны 50 м² гадаргуу тутамд барилгын гадна нүүрэнд нэг бэхэлгээ хийх замаар гүйцэтгэсэн байвал зохино.

Шатны бэхэлгээг барилга, байгууламжийн хашлага хана, карниз, тагт ба бусад өнгийлтийн хэсэгт хийхийг хориглоно.

7.4.8.Тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн ойролцоо байрлах шатыг тээврийн хэрэгслийн овроос 0.6 м-ээс ойргүй зайд дохионы шон байрлуулсан хашлага хийсэн байвал зохино.

7.4.9.Ажил гүйцэтгэх явцад шатанд үйлчлэх ачаа ба үйлчлэл нь техникийн нөхцөл болон төсөлд тооцогдсоноос илүү байж болохгүй. Шат, ванданд дамжигдах нэмэлт ачаа (материал өргөх машин, ачаа өргөх талбайгаас г.м) үйлчлэх тохиолдолд тэдгээрийн бүтээцийг эдгээр ачаалалд шалгаж, тооцсон байвал зохино.

7.4.10.Шат, вандангаар хүн-өгсөх хэсэгт зөвшөөрөгдөх ачааны дээд хэмжээ,байршил, аюул, ослын нөхцөлд ажиллагчдыг гаргах схем зураг, сурталчилгаа, самбар байрлуулсан байвал зохино. Шатны өгсөх, уруудах хэсэг нь гишгүүртэй байна.

7.4.11.Шатны хучилт, явах хэсэг нь тэгш гадаргуутай, банзны хоорондын зай 5мм-ээс илүүгүй байх ба 1.3 м-ээс илүү өндөрт байрлах шатны тавцан нь хайс, хормойвчтой байна. Хайсны өндөр 1.1м-ээс богиногүй, хормойвчийн өндөр 0.1м-ээс багагүй, хөндлөвч-хашлага 0.5 м-ээс илүүгүй байна.

7.4.12.Шавардлага, заслын ажилд хэрэглэх шатны доор бусад ажил явагдах, явах хэсэг байрлах нөхцөлд хучилт, шалыг ямар ч зай завсаргүй нягт шахсан байвал зохино.

7.4.13.Шатны дэвсгэр шалны банзыг уртын дагуу давхарлан зөрүүлж холбохыг зөвшөөрөх ба холбогдох зүйдлийн хэсэг нь тулаасан дээр байрлах ба зөрүүлгийн хэмжээ тал бүрд 0.2 м-ээс багагүй байвал зохино.

7.4.14.Шат, вандангийн өндөр нь 4 м хүртэл бол түүнийг ажил гүйцэтгэгч, мастер хүлээн авч, ажлын журналд бүртгэсний дараа, харин 4 м-ээс илүү өндөртэй шат, ванданг барилга угсралтын байгууллагын удирдлагын томилсон комисс хүлээн авч, акт үйлдсэний дараа тус тус ашиглахыг зөвшөөрнө.

7.4.15.6 м ба түүнээс өндөр шатнаас ажил гүйцэтгэх нөхцөлд ажлын (дээд, доод), хамгаалалтын хоёроос доошгүй тавцан (хучилт)-тай байх ба ажлын байр нь барилга, байгууламжийн хананд тулж байрласан байхаас гадна ажлын тавцангаас 2м-ээс илүүгүй өндөрт байрлах шатны тавцангаар хамгаалагдсан байвал зохино.

Шатан дор ажил гүйцэтгэх, хүмүүсийн хөдөлгөөн төлөвлөгдөөгүй, шатны ойролцоо тээврийн хөдөлгөөн хийгдэхгүй тохиолдолд хамгаалалтын (доод) хучилт байх шаардлагагүй.

7.4.16.Шатны ойролцоо хүмүүсийн хөдөлгөөн, урсгал зохион байгуулахад гарцыг хамгаалалтыг тууш саравчаар тоноглох ба шатны нүүр талыг 5х5 мм-ээс илүүгүй тороор битүүлж, хамгаалалт хийсэн байвал зохино.

7.4.17.Ашиглалтын явцад барилгын ажлын шатны байдлыг 10 хоног тутам нэг удаа даамал буюу хэсгийн инженер, ахлагч биечлэн үзлэг, шалгалт хийж байвал зохино. Ажлын шатнаас сар ба түүнээс илүү хугацаанд ажил хийгдээгүй бол дахин ажил гүйцэтгэхийн өмнө энэ дүрмийн 7.4.14 зүйлд заасан журмаар ашиглалтад хүлээн авбал зохино.

Бороо хур, үер, салхи шуурга, газар хөдлөлтийн дараа ажлын шат, түүнд хамаарах хэрэгслийн даацын эд ангиудад үүссэн байж болох хэв гажилт, буурь хөрсний даацын чадавхид үүссэн нөлөөллийг нэмэлт үзлэгт хамруулан тодорхойлвол зохино.

Үзлэгээр ажлын шатны даацын бүтээцэд хэв гажилт, хөрсний даацын чадавхид өөрчлөлт илэрсэн тохиолдолд эдгээр зөрчлийг арилгах арга хэмжээ авч, ажлын шатыг 7.4.14 зүйлд тогтоосон журмаар дахин хүлээн авна.

7.4.18.Барилгын хананд тулган угсарсан ажлын шатыг буулгах явцад нэгдүгээр давхрын хаалга суулгах онгорхойнууд, бүх давхруудын тагтны гарцыг (буулгах хэсгийн хязгаарт) битүүлэн хаасан байвал зохино.

7.4.19.Хөдөлгөөнт шат, хэрэгслийг ашиглах үед дараах шаардлагуудыг хангасан байвал зохино:

- Шат, ажил гүйцэтгэх хэрэгслийг шилжүүлэх хөндлөн, дагуу чиглэлийн гадаргуугийн налуугийн хэмжээ нь паспортод заагдсан үйлдвэрлэгч-заавын ашиглалтын зааварт заагдсан хэмжээнээс илүү байх ёсгүй.

- 10 м/с-ээс илүү хурдтай салхитай үед шат хэрэгслийг нүүлгэн шилжүүлэхийг хориглоно.

- Шат, түүний хэрэгслийг шилжүүлэхийн өмнө материал, сав, баглаа боодлоос бүрэн чөлөөлсөн байхаас гадна түүн дээр хүн байхыг хориглоно.

- Шатны хашлаган дахь хаалгыг дотогш нээгдэхээр хийсэн байхаас гадна чөлөөтэй нээгдэх боломжийг хязгаарласан, давхар чиглүүлэгчтэй байвал зохино.

7.4.20.Дүүжин шат, ванданг угсарч нэг цагийн турш хэвийн ачааллаас 20% илүү статик ачаалалд туршиж, шаардлага хангасны дараа ашиглалтын зөвшөөрлийг олгоно.

Үүний дараа өргөх ванданг хэвийн хэмжээнээс 10% илүү динамик (хөдөлгөөнт) ачаалалд туршсан байвал зохино.

Дүүжин шат, вандангийн сорилт туршилтын үр дүнг актад тусгах буюу ажлын журналд бүртгэсэн байвал зохино.

Дүүжин шат, ванданг дахин ашиглах тохиолдолд шатны дүүжлэх бүтээцийг тооцооны ачаанаас 2-оос багагүй дахин ачаалалд шалгагдсан, шаардлагатай туршилтыг хангах нэг маягийн зангилгаагаар бэхлэгдсэн нөхцөлд тэдгээрийг туршихгүйгээр ашиглалтад оруулж болно.

7.4.21.Барилга угсралтын ажил гүйцэтгэхэд хэрэглэх дүүжин шат, вандангийн бүтээц нь ГОСТ 27372-87 стандартын шаардлагыг хангасан байвал зохино.

7.4.22.Дүүжин (өргөгдөгч) шатыг ажлын засварлагын үед газарт буулгасан байх ёстой. Өргөгдөгч шатнаас барилга байгууламжид шилжиж орох ба буцахыг хориглоно.

7.4.23.Зөөврийн угсармал бус (шат, гишгүүр, трап ба гүүр) шатыг төмөр буюу I ба II зэргийн шилмүүст модны зүсмэлээр хийж, бэлтгэсэн байвал зохино.

7.4.24.Тулган байрлуулах модон шатны урт 5 м -ээс илүүгүй байвал зохино.

7.4.25.Ажлын шатны өгсөх хэсгийн налуу 60°-аас хэтэрч болохгүй.

7.4.26.Шатыг ашиглахын өмнө суурилуулсан шатны алслалын дунд байрлах гишгүүр дээр 1200Н (120кгс) статик ачаагаар туршсан байвал зохино. Барилга байгууламжийн ашиглалтын явцад модон шатыг хагас жил бүр, төмөр шатыг жил тутам туршиж байвал зохино.

7.4.27.Ажлын талбайгүй тулган байрлуулсан шатыг зөвхөн баригдаж байгаа барилгын давхар хооронд шилжих ба тулаас шаардахгүй барилгын бүтээцийн ажил гүйцэтгэхэд хэрэглэхийг зөвшөөрнө.

Тулаасан ба өлгөөсөн шатууд нь ашиглалтын үед шилжих ба холбирохоос урьдчилан сэргийлэх тоноглолоор хангагдсан байвал зохино. Тулаасан ба өлгөөсөн шатны доод төгсгөлд хурц үзүүр бүхий бүслүүр тавьж хөрсөнд суулгах ба харин (паркет, төмөр хавтанцар, бетон г.м) толигор гадаргуу дээр тулах шат ашиглах үед гулсдаггүй материалаар ивүүр, дэр хийсэн байвал зохино.

7.4.28.Хийц, бүтээц дээр ажил гүйцэтгэх зориулалтаар хэрэглэх дүүжин шат, тавцан нь бат бэх бэхэлгээг хангаж чадахуйц тусгай бэхлэгч-дэгээгээр хангагдсан байвал зохино. Тэдгээрийг угсрагдах бүтээцэд угсрахын өмнө байрлуулан бэхэлсэн байвал зохино.

Тулаасан шатны хэмжээ нь ажилчид, шатны дээд төгсгөлөөс 1 м-ээс багагүй зайд байрлах гишгүүр дээр зогсоо байдлаар ажил гүйцэтгэх боломжийг хангахуйц байвал зохино.

1,3 м-ээс дээш өндөрт тулаасан шатнаас ажил гүйцэтгэх үед байгууламжийн бүтээцэд буюу барилгын бүтээцэд бэхэлсэн шатанд бэхлэгдсэн хамгаалах бүс хэрэглэвэл зохино.

7.4.29.Тээврийн хэрэгсэл болон хүмүүсийн хөл хөдөлгөөн ихтэй хэсэгт тулаасан шатыг байрлуулах орчныг ажил гүйцэтгэх хугацаанд хайс, хашлагаар хаах буюу хамгаалалтад авсан байвал зохино.

7.4.30.Дор дурдсан ажлуудыг гүйцэтгэхийг хориглоно.

- Ажиллаж байгаа туузан зөөгүүр, машины эргэж байгаа эд ангийн ойролцоо зөөврийн тулаасан ба өлгөөсөн шатан дээр ажил гүйцэтгэх;

- Цахилгаанжсан гар ба хийн багаж ашиглах; - Хийн ба цахилгаан гагнуурын ажил;

- Овор ихтэй, хүнд эд анги барих ба төмөр утас сунгах;

Эдгээр ажлуудыг гүйцэтгэхэд ажлын шат, вандан, бариултай шат бүхий талбайтай шат ашиглавал зохино.

7.4.31.Нийтийн хамгаалах хэрэгслийг суурилуулах буюу буулгаж авахдаа ажиллагсадын аюулгүй байдлыг хангасан найдвартай угсарч, суурилагдсан буюу хамгаалалтын байгууламжид бэхлэгдсэн хамгаалах бүс хэрэглэн технологийн дарааллаар гүйцэтгэвэл зохино.

Хашлагыг суурилуулах ба буулгах ажлыг үйлдвэрлэгч - заводын ашиглалтын баримт бичгийн дагуу тусгайлан сургалтад хамрагдсан, бригадын бүрэлдэхүүнд багтах ажилчид гүйцэтгэвэл зохино.

7.4.32.Цахилгаанжсан гар багажийг дараах нөхцлийг хангасан тохиолдолд ашиглана.

- Машиныг ажиллуулахын өмнө түүний иж бүрдэл, эд ангиудын найдвартай бэхэлгээ, хамгаалах бүрхэвч, кабелийн бүрэн байдлыг тогтмол шалгаж байвал зохино.

- Ажил эхлэхийн өмнө машиныг болон түүний унтраалгын бүрэн бүтэн байдлыг ачаалалгүй сул ажиллуулж шалгасан байвал зохино.

- Ажлын завсарлага, ээлжийн ажлын төгсгөл, цэвэрлэгээ ба тосолгоо хийх үед болон ажлын багажийг солиход машиныг унтраасан, цахилгаан гүйдэл, хий дамжуулах шугамнаас салгасан байвал зохино.

- Ажиллагчийн гарт ногдох жин 10кг-аас илүү байх гар багажийг дүүжин хэрэгсэлтэйгээр ажиллуулвал зохино.

- Өндөрт машинаар ажил гүйцэтгэх нөхцөлд тогтвортой. вандан (тавцан) ашиглавал зохино.

- Ажлын тоног төхөөрөмжийг солих, тосолгоо, засвар хийх, ирлэх болон тохируулах, эд ангийг солих ажлыг тухайлсан ажилтнаар гүйцэтгүүлвэл зохино.

7.4.33.Цахилгаанжсан гар багаж нь ГОСТ 12.2.013.0-91 стандартын шаардлагыг хангасан байх ёстой.

Цахилгаанжсан гар багажаар ажиллагч нь цахилгааны аюулгүй байдлын нэгдүгээр зэрэгтэй байх ба түүнийг жил бүр баталгаажуулж байх шаардлагатай.

7.4.34.Тасалгааны гадна ажил гүйцэтгэх бүх тохиолдолд, харин тасалгаанд ажиллагч цахилгаан гүйдэлд цохиулах илүү аюултай нөхцөлд ГОСТ 12.1.007.0-75 стандартын дагуу II ба III ангилалын цахилгаанжсан гар багаж хэрэглэх шаардлагатай.

II ангилалын машинаар ажиллах үед нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (тусгаарлагч улавч, дэвсгэр, тусгаарлагч бээлий) хэрэглэвэл зохино.

Ажиллагч цахилгаан гүйдэлд цохиулах онцгой аюултай нөхцөл (зуух, битүү саванд ажиллах)-д зөвхөн III ангилалын цахилгаанжсан гар багаж ашиглах ба тусгаарлагу углааш, бээлий ба дэвсгэр хэрэглэвэл зохино.

7.4.35.II ангилалын цахилгаанжсан гар багаж хэрэглэх бүх тохиолдолд тэдгээрийг тусгаарлах ороомог бүхий шулуутгагчаар буюу бууруулах трансформатороор дамжуулан залгасан байвал зохино.

7.4.36.Хийн ажиллагаат гар багажууд нь ГОСТ 12.2.010-75 стандартын шаардлагыг хангаж байвал зохино.

Хийн ажиллагаат гар багажаар ажиллахдаа дараах зүйлийг анхаарвал зохино.

- машиныг (туршихаас бусад тохиолдолд) ачаалалгүй сул ажиллуулахгүй байх;

- элдэв гэмтэл, согог илэрсэн тохиолдолд ажлаа зогсоож, машиныг засварт шилжүүлэх;

- шахсан хий дамжуулах шугам болон нүүдлийн компрессорын хийн даралт машины ажлын даралттай тохирч байгаа эсэхийг ямагт хянах;

Хийн хоолойд шахсан хий байх үед ажлын багажийг солихыг хориглоно.

7.4.37.Цохилтын буюу эргэх үйлчлэлийн хийн машинаар ажиллагч, алгандаа доргилтын хамгаалах хавчуурга бүхий зөөлөн бээлий хэрэглэвэл зохино.

7.4.38.Барилгын үйлдвэрлэлд хэрэглэж байгаа багаж нь 10 хоногт нэгээс цөөнгүй удаа, тэрчлэн хэрэглэхийн өмнө үзлэгт хамруулж байвал зохино. Аюулгүйн шаардлага хангаагүй багаж хэрэгслийг тухай бүр ашиглалтаас хасч байвал зохино.

7.4.39.Багаж хэрэгслийг зөөвөрлөх үед түүний хурц үзүүрийн эд ангийг бүрээсээр бүрж хамгаалсан байна.

7.4.40.Сүх, алх, зээтүү ба бусад цохилтын багаж хэрэгслийн иш (барил) -ийг хатуу төрлийн (царс, агч, яшил тэс /сэндэн/, хайлаас, яргай г.м) модоор зуйван дугуй хэлбэрийн хөндлөн огтлолтойгоор хийсэн байвал зохино. Ишний багаж суулгах

төгсгөл нь шаантагласан байх шаардлагатай.

8.Тээвэрлэлтийн болон ачиж, буулгах ажил

8.1.Ерөнхий шаардлага

8.1.1.Барилгын үйлдвэрлэлийн тээвэр, ачилт, буулгалтын ажилд энэхүү норм ба дүрмийн зэрэгцээгээр автотээврийн хөдөлмөр хамгааллын MNS 5079:2001, ГОСТ 12.3.020-80 стандартуудыг мөрдвөл зохино.

8.1.2.Ачиж, буулгах ажилд хэрэглэх тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нь ачиж, зөөвөрлөж, буулгаж байгаа ачааны шинж чанартай дүйцэж байвал зохино. Ачиж, буулгах ажлын талбай нь тэгшилсэн, 1:10 -аас илүүгүй налуутай байх ба хэмжээ болон хучлага нь ажил гүйцэтгэх төсөлд заагдсаны дагуу хийгдсэн байвал зохино. "Орц", "Тарц", "Эргэлт"-ийг зохих байранд үзэгдэхүйцээр бичиж тавьсан байна.

Өгсөх, уруудах хэсэгт өвлийн улиралд замын цас, мөсийг байнга цэвэрлэж, элс, үнс цацаж байвал зохино.

8.1.3.Ширхэгийн болон нунтаг материал буулгах зориулалтын тавцан нь зохих маркийн ачааны автомашины бүрэн ачааг хүлээн авах тодорхой нөөцтэйгээр тооцогдсон байх ба даацын зөвшөөрөгдөх дээд хязгаарыг заасан тэмдгүүдийг байрлуулах ба хажуу талаараа дугуй хязгаарлалын дохионы шонгууд байрлуулсан байвал зохино.

8.1.4.Сав, баглаа, боодол (баглаа, боодол, торх, боошиг, хуйлмал г.м) –той материал агуулах зориулалтын ачилт, буулгалтын талбайд автомашины тэвшний шалны түвшинтэй тэнцүү өндөртэй тавцан хийсэн байвал зохино.

8.1.5.Үйлдвэрлэлийн талбай-, ачих, буулгах талбайн орох, гарах зам, автомашины хөдөлгөөнийг замын ерөнхий заалт, тэмдгүүдээр зохицуулна.

8.1.6.Ачиж, буулгах талбайд автомашиныг цуваагаар өөр хооронд нь 1м-ээс багагүй, зэрэгцээгээр 1,5 м-ээс багагүй зайтайгаар байрлуулна.

Автомашины барилга байгууламжийн ойролцоо ачаа ачихаар байрлуулахад барилга объект, машины тэвшний арын хашлагын хоорондын зай 0,5 м-ээс багагүй байвал зохино. Хураалттай материал ба автомашины хоорондын зай 1м-ээс багагүй байвал зохино.

8.1.7.Ачилт, буулгалтын ажил гүйцэтгэхэд ачаа өргөж, шилжүүлэх жингийн дээд хязгаарыг тогтоож, ажилчдаар энэ ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрөх тухай шаардлагыг хангасан байвал зохино.

8.1.8.Онцгой тохиолдолд дамнуургаар ачааг тэгш хэвтээ гадаргуугаар 50м-ээс илүүгүй зайд зөөвөрлөхийг зөвшөөрнө.

Дамнуургаар материалыг шат ба өлгөөсөн шатаар зөөхийг хориглоно. Нэгээс дээш давхарт байрлалтай 2 м-ээс илүү өндөртэй шат бүхий агуулахыг ачаа өргөх ба буулгах өргөгч төхөөрөмжөөр тоногловол зохино.

8.2.Ачиж, буулгах ажлыг гүйцэтгэх үйл ажиллагаанд тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

8.2.1.Ачиж, буулгах ажил хийгдэх талбай ба өрөө тасалгааны гэрэлтүүлэг нь СНиП 23-05-95 -ийн шаардлагыг хангасан байвал зохино.

8.2.2.Ачиж, буулгах ажлыг механикжсан аргаар, өргө-тээвэрлэх тоног төхөөрөмжийн туслалцаатай, байгууллагын удирдагч-захирагчийн тушаалаар томилогдсон, краны аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтны удирдлагаар гүйцэтгэвэл зохино.

8.2.3.Ачиж, буулгах ажлыг хариуцагч албан тушаалтан ачаа өргөх механизм, оосорлох тоног, хэрэгсэл, шат вандан гэх мэт ачиж буулгах хэрэгсэл, төхөөргийн бүрэн байдлыг шалгах үүрэгтэй ба ажилтнуудад тэдгээрийн үүрэг, үйлдлийн дараалал, өгөгдөх дохиоллын агуулга, ачилт ба буулгалтад өгөгдсөн материалын шинж чанарыг тайлбарлан таниулах үүргийг нэг адил хүлээнэ.

8.2.4.50 кг-аас дээш жинтэй болон 2 м-ээс дээш өндөрт өргөн тээвэрлэх ачааг ачих, буулгахдаа заавал механикжсан аргыг хэрэглэвэл зохино.

8.2.5.Байгууллага, хувь хүмүүс ачаа өргөх машин хэрэглэх нөхцөлд машинч ба оосорлогч-дохиочныг сургалтад хамруулахын зэрэгцээ ачааг зөв оосорлох арга хэлбэрийг боловсруулан, гүүрэн төрлийн краны машинчийн аюулгүй ажиллагааны заавар, кранаар ачаа шилжүүлж ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагчийн ажлын заавар, оосорлогч дохиочны аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллавал зохино.

Өргөн тээвэрлэх үндсэн ачааны жагсаалт, тэдгээрийг өргөн тээвэрлэх, оосорлох аргыг зургаар үзүүлэн, өргөх ачааны жинг заасан материалыг оосорлогч, машинчид өгөхийн зэрэгцээ ажлын байранд зүүсэн байвал зохино.

8.2.6.Ачиж, буулгах ажил гүйцэтгэх байр, ачаа өргөх машины ажлын бүсэд, энэ ажилд хамааралгүй гадны хүмүүс байхыг хориглоно.

Ачааны нурах, унаж болох бүсэд хүмүүс, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн үйлдэхийг хориглоно.

Ачааг ачих, буулгах ажил гүйцэтгэх зөвшөөрлийг жолооч нараас гаргуулан авч болно.

8.2.7.Ачаа ачих тавцан, автомашины тэвшний шалны өндөр харилцан адилгүй түвшинд байх тохиолдолд гүүр хэрэглэвэл зохино.

8.2.8.Хавтгаалж, гулдмай ба бусад угсармал төмөр бетон эдлэхүүнийг ачих, буулгахын өмнө угсралтын гох, дэгээг шалгаж, элдэв наалдацыг цэвэрлэн, бүтээцийг гэмтээхгүйгээр тэгшилвэл зохино.

8.2.9.Эмнэлэгийн үзлэгийн дүнгээр MNS 4978:2000-д заасан осолтой ба онцгой аюултай ачааг ачих (буулгах) ажил гүйцэтгэх эрх олгогдсон ажилтнуудыг эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх арга барил, мэдлэг олгох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тусгай сургалтад хамруулан, аттестатчилж байвал зохино.

8.2.10.Аюултай ачаа ачих, буулгах ажил гүйцэтгэхийн өмнө аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчлага өгч байвал зохино. Зааварчлагын хөтөлбөрт аюултай ачааны шинж чанар, тэдгээртэй ажиллах дүрэм, эмнэлэгийн анхан шатны тусламжийн арга хэмжээний тухай мэдэгдэхүүнийг оруулсан байвал зохино.

8.2.11.Үйлдвэрлэлийн аюултай буюу хортой хүчин зүйлийн үйлчлэлийн хэсэгт хийгдэх ачилт, буулгалтын ажлыг ажил гүйцэтгэх-зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

8.2.12.Аюултай ачааг ачиж, буулгах, шилжүүлэх ажлыг MNS 4978:2000 стандартын дагуу аюул ослын зэрэг, ачаа илгээгчээс аюулгүйн арга хэмжээг мөрдөх заалт байгаа тохиолдолд тусгайлан бэлтгэсэн газарт гүйцэтгэвэл зохино.

8.2.13.Зохих журмын дагуу батлагдсан норматив техникийн баримт бичгийн шаардлагад нийцэхгүй савлагаатай, сав нь бүрэн бус, марклалт ба урьдчилан сануулах бичиг, тэмдэглэгээ хийгдээгүй болох нь илэрсэн нөхцөлд аюултай ачааг буулгах, ачих ажил гүйцэтгэхийг хориглоно.

8.2.14.Ширхэгийн болон нунтаг, тоосорхог ба аюултай материал ачиж, буулгах үйлдлийг, гүйцэтгэх ажлын шинж чанарт нийцсэн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглан механикжсан хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэвэл зохино. Тоосжилттой (цемент, шохой г.м) материалыг гараар ачих, буулгах үйлдлийг материалуудын температур 40°C-ээс илүүгүй байх нөхцөлд зөвшөөрнө.

8.2.15.Автомашины хөдөлгүүрээр хөтлөгдөгч, автомашинд суурилагдсан насосоор ачилт ба юүлэлт хийх тохиолдлоос бусад нөхцөлд аюултай ачааг машинд ачих, түүнийг автомашинаас буулгахдаа хөдөлгүүрийг унтраасан байвал зохино. Энэ тохиолдолд жолооч насосны удирдлагын байранд байх ёстой.

8.2.16.Ачаа өргөх кран хэрэглэн ачиж, буулгах ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааг хангахын тулд ажил гүйцэтгэгч эзэн, байгууллага дор дурдсан шаардлагуудыг хангасан байвал зохино.

- Ажил явагдах байр, орчинд ажил гүйцэтгэхтэй холбоогүй хүмүүс байхыг хориглоно.

- Автомашины бүхээг, тэвшинд хүмүүс байх нөхцөлд ачааг машины тэвш дээр буулгах, өргөхийг хориглоно.

- Автомашинд болон хагас вагонд тогтмол ачиж, буулгах ажил хийгдэх газруудад оосорлогчидод зориулж байнгын тавцан барих, эсхүл дүүжин талбай гаргасан байна.

- Хагас вагонд дэгээт кранаар ачилт, буулгалтыг хийхдээ краны эзэмшигчийн заавар технологиор гүйцэтгэх ба тухайн технологид ачаа шилжих үед оосорлогч-дохиочны байрлах байр, тэдгээрийн тавцан, саравчтай талбайд аюулгүй гарах боломжийг тодорхойлон заасан байвал зохино.

- Ачаа шилжүүлэх үед хагас вагонд хүмүүс байхыг хориглоно.

8.2.17. Ачаа ачих, буулгах үед дцхиолол, оосорлох ажлыг, тухайн ажлыг гүйцэтгэх эрхийн үнэмлэх бүхий тусгай сургалтад хамрагдсан хүмүүсээр гүйцэтгүүлвэл зохино.

8.2.18. Ачаа өргөх машины дэгээнд ачааг өлгөх, оосорлох ажиллагааг оосорлогч-дохиочин гүйцэтгэнэ. Мэргэжлийн тодорхойлолтод нь ачаа оосорлох ажил багтдаг сургалтад хамрагдсан бусад ажилчид (дохиочин, угсрагч г.м)-ыг оосорлогчоор ажиллуулж болно. Ийм ажилчдын үнэмлэхэд оосорлогчийн мэргэжил хослон эзэмшсэн тухай бичилт хийгдсэн байвал зохино.

8.2.19. Ачаа оосорлох аргууд нь оосорлосон ачаа шувтрах, унах боломжийг хаасан байвал зохино. Ачааг тээврийн хэрэгсэлд тогтвортой байдлаар байршуулсан байвал зохино.

8.2.20. Ачилт, буулгалтын ажлын үед тогтвортой бус байрлалд байгаа ачааг оосорлох, өргөөстэй байгаа ачааны оосорлох төхөөрөмжийн байрлалыг засах, татлагын ташуу байдалд ачаа өргөхийг хориглоно.

8.2.21. Ачаа шилжүүлэх шал, тавцангийн гадаргуу өөгүй, тэгшхэн, ан цав, завсаргүй, холцорч, эмтрээгүй, ирмэгийн эмжээр булан, даруулгууд босож, сөртийгөөгүй байвал зохино.

Ачаа өргөх явцууд нь MNS 5079:2001 стандартын шаардлагыг хангасан байвал зохино.

8.2.22. Аюултай ачаа ачиж, буулгасны дараа ажил гүйцэтгэсэн талбай, өргөн тээвэрлэх тоног төхөөрөмж, оосорлох хэрэгсэл, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ачааны шинж чанараас хамааруулан холбогдох ариутгал, хоргүйжүүлэх боловсруулалт хийнэ.

8.3. Үйлдвэрийн талбайд ачаа шилжүүлэх үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

8.3.1. Цех дотор болон цех хооронд ачаа тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслээр хүн тээвэрлэхийг хориглоно.

8.3.2. Ширхэгийн ачааг тэргэнцэрийн ачааны талбайн оврын хэмжээнд тохируулан хураасан байвал зохино. Бага хэмжээтэй ширхэгийн ачааг савлаж тээвэрлэнэ.

Тээвэрлэх ачааны жиьг тухайн тээврийн хэрэгслийн даацаас хэтрэхгүй байвал зохино.

8.3.3. Ачааг кранаар ачих, буулгах үед жолоочийг бүхээгтээ байхыг хориглоно.

8.3.4. Сэрээт авто ба цахилгаан ачигчид ачааг авах, өргөх, тээвэрлэх, буулгах үед нурах боломжгүйгээр байрлуулбал зохино.

8.3.5. Авто ба цахилгаан ачигч ажиллаж байх үед дараах үйлдлийг хориглоно.

- Сэрээгээр ачааг хурдтайгаар мөргөн авч ачих;

- Ул тавиуртай ачааг сэрээн дээр машинч руу чиглэсэн налалттайгаар өргөх;

- Хөдөлгөөний явцад ачааны налалтын өнцгийг өөрчлөх, өргөх, буулгах;

- Сэрээг машинчид налалттайгаар байхад ул тавиуртай ачааг сэрээнд өлгөх;

- Ачааг 1 м-ээс илүү өндөрт өргөж зөөвөрлөх;

- Жин нь мэдэгдэхгүй ачаа, авто ба цахилгаан ачигчаар өргөх зориулалтын бус ачаа (металл хуудас, салхилуурын хайрцаг г.м) болон барьцалдаж, хөлдсөн ачааг өргөхийг оролдох;

Авто ачигчийн хурд саад бартаатай замд болон ухрах хөдөлгөөний үед 3 км/цаг -аас илүүгүй байна.

8.3.6. Тээврийн хөдөлгөөний үед ачаа унах, шилжихээс хамгаалахын тулд тухайн

ачааны ачих, бэхлэх хехникийн нөхцлийн дагуу тээврийн хэрэгсэлд ачааг зөв, тогтвортой байдлаар байрлуулан бэхэлсэн байвал зохино.

8.3.7. Ачааг тээврийн хэрэгсэлд ачихдаа замд тохиолдох хонгил, гүүр, тээвэрлэгдэж буй бусад ачаа, тээврийн нөхцлийг үндэслэн тээвэрлэх ачаа, тээврийн хэрэгслийн оврыг зөвөөр сонгосон байвал зохино.

8.3.8. Хайрцагтай ачааг вагон, төмөр замын болон бусад агуулахуудад нуруулдаж, тогтвортой байдлаар хураана. Ачааны нурууны өндөр нь гараар ачилт хийхэд 3 м, механикжсан аргаар ачилт хийх нөхцөлд 6 м-ээс тус тус хэтрэхгүй байвал зохино.

Хайрцаг багцтай ачааг битүү агуулахад нуруу хоорондын явах хэсгийн хоорондын зай 3 м-ээс багагүй байхаар хураана.

8.3.9. Шилэн савтай ачааг зөөвөрлөхөд цохилт, доргилтоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байвал зохино.

8.3.10. Баллоныг тусгай зориулалтын дамнуурга буюу тэргэнцэрээр, харин шилэн савтай хүчил, шүлт болон бусад аюултай шингэнийг сүлжмэл сагсанд тус тус зөөвөрлөх буюу тээвэрлэнэ. Эдгээр ачааг өндөрт өргөхдөө тусгай зориулалтын чингэлэг хэрэглэвэл зохино. Гар аргаар өргөхийг хориглоно.

8.3.11. Шахсан хийтэй баллон, торхтой карбид калыц, тэрчлэн шилэн савтай материалыг шилжүүлэх, зөөх үед цохилт, түлхэлтээс хамгаалах арга хэмжээ авсан байх шаардлагатай.

Хүчилтөрөгчийн баллоныг шатах, хурдан шатах шингэн, тостой хамт зөөвөрлөх, тээвэрлэхийг хориглоно.

8.3.12. Ширхэгийн хүнд материал, ачаатай хайрцгийг шилжүүлэн тавихдаа тусгай царил болон бусад хэрэгсэл ашиглана.

8.3.13. Өнхрөгч ачаа (дамартай кабель, утас, татлага г.м)-г ачиж, буулгах үйлдлийг механикжсан аргаар гүйцэтгэнэ. Онцгой тохиолдолд налуу талбай ашиглах буюу гуалин, шургааг хэрэглэн эсрэг талаас нь татлагаар барин сааруулах замаар өнхрүүлэн буулгаж болно. Энэ үед ажилчид өргөж байгаа буюу буулгаж байгаа ачаанаас хол хөндий байвал зохино.

8.3.14. Торхтой болон хуйлаастай өнхрөгч ачааг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн буюу автомашины тэвшний шал нь агуулахын шалтай нэг түвшинд байх нөхцөлд гараар өнхрүүлэн ачихыг зөвшөөрнө.

8.4. Тасралтгүй ажиллагаатай машин хэрэглэх үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

8.4.1. Дараалан суурилагдаж, нэг зэрэг ажиллах тасралтгүй ажиллагаатай тээврийн хэрэгсэл (туузан зөөгүүр, конвейер г.м) -үүдээс бүрдсэн, технологийн шугамууд дараах хамгаалалт, дохиоллоор хангагдсан байвал зохино.

а) Удирдлагын бүх цэг, салбаруудад хоёр талын дохиололтой;

б) Зогсоосон буюу зогсоохоор бэлтгэгдэж байгаа (агрегат) эд ангийн ачааллыг гүйцэтгэж буй технологийн шугамын аль нэгийг автоматаар салгах үйлдлийг хангах тоног төхөөрөмжөөр хангах.

8.4.2. Тасралтгүй ажиллагаа бүхий машин хэрэглэн ачиж, буулгах ажил гүйцэтгэхэд дараах шардлагуудыг хангасан байна:

- Машины ажлын тоног, хэрэгслийг жигд тогтвортой байдлаар ачаалахаар ачааг хуваарилан өгөх;

- Машины ажлын тоног хэрэгслээс авах ба өгөх үйл ажиллагааг тусгай төхөөрөмжийн тусламжтайгаар гүйцэтгэж байх.

8.4.3. Туузан зөөгүүрийг ажиллаж байх явцад дараах үйлдлүүдийг хориглоно:

- Хөтлөгч хүрд дээр хий эргэх саатлыг арилгах зорилгоор тууз, хөтлөгч булны хооронд элс, шавар, давирхай, битум, бусад материал цацах;

- Тулгуур роликууд, хөтлөгч хүрд, чангалах, төгсгөлийн станц, туузан дороос асарч тогтсон овоолго зэргийг цэвэрлэх;

- Тулгуур роликийг шилжүүлэн тавих, зөөгүүрийн туузыг гараар тэгшлэх, чангалахыг

тус тус хориглоно.

Заагдсан ажлуудыг MNS4643:1998 стандартын шаардлагын дагуу зөөгүүрийг-сүлжээнээс салгаж, бүрэн зогсоон, гал хамгаалагчдыг авсан, залгах тоноглолыг хааж, "Залгаж болохгүй. Хүмүүс ажиллаж байна" гэсэн аюулгүйн хориглох тэмдгийг зүүсэн нөхцөлд гүйцэтгэнэ.

8.4.4.Туузан зөөгүүрийг асгаасаар дарагдаж, шилжих, явах боломжгүй болсон, түүнчлэн дараах гэмтэл, саатлын үед залгахыг хориглоно:

- Хөтлөгч, чангалагч ба төгсгөлийн хүрдний хашлагагүй;
- Утсан салгуургүй;
- Цахилгаан төхөөрөмжийн газардуулга, кабелийн бүрээс, туузан зөөгүүрийн арал гэмтэлтэй үед залгахыг хориглоно.

8.4.5.Ачааг гараар зөөвөрлөхөд туузан зөөгүүрийн хөдөлгөөний хурд 0.5 м/с-ээс илүүгүй, ачааны хүндийн жин 5 кг ба түүнээс илүү байх нөхцөлд 0.3 м/с байвал зохино.

8.4.6.Тээвэрлэж байгаа түүхий эдийн асгарах, гоожих, үйлдвэрлэлийн байранд тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шурган зөөгүүрийн таг ба цоргууд нягт тавигдсан байвал зохино.

8.4.7.Шурган зөөгүүрийг ажиллаж байх явц дунд хориглох зүйлс:

- бүрэн зогсоох, залгагдахаас сэргийлэх арга хэмжээ авахаас өмнө шурган зөөгүүрийн нээлхийг сөхөх, дээгүүр нь явах;
- тээвэрлэж байгаа материалд тохиолдлоор орсон элдэв зүйлсийг чихэх, түлхэх, лабораторийн туршилтын дээж авах;
- шураг гадна бүрээсэнд хавирах, бүрэн бус нээлхий, хангалттай бус битүүмжлэлтэй шурган зөөгүүрийг ашиглахыг хориглоно.

8.4.8.Дүүжин тэргэнцэр, түлхэгч конвейероор тээвэрлэх явцад материал эдлэхүүн унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байвал зохино.

Конвейер нь хэт ачаалсан үед хөтлөгчийг шуурхай салгах төхөөрөмжөөр тоноглогдсон байвал зохино.

8.4.9.Шинээр угсарсан буюу их засвар хийгдсэн конвейеруудыг ашиглалтад оруулахын өмнө татах, дүүжин байгууламжуудыг ажлын ачааллаас 2 дахин илүү ачаагаар 15 минутын турш сорьж, туршсан байна.

8.4.10.Дүүжин конвейерын зүүх төхөөрөмж нь тээвэрлэж байгаа ачааг байрлуулах ба авахад тохиромжтой нөхцлийг хангасан байвал зохино.

8.4.11.Өлгийт конвейерын хөтлөгч ба эргэлтийн цагираган дугуй, араа, хөтлөгчийн холбогч муфтүүдэд цул төмөр болон торон хаалт хийсэн байвал зохино.

8.4.12.Конвейер доогуур тээврийн хэрэгсэл болон явган хүн зорчих хэсэгт конвейерээс унаж байгаа ачааг хуримтлуулах төмөр тор байрлуулвал зохино.

Тор суулгах өндөр нь газрын түвшнөөс дээш, хэрэглэж байгаа дугуйт ачигчийн оворот дүйцэж байх ба хүмүүс чөлөөтэй явж өнгөрөх шаардлагыг хангасан байвал зохино.

8.5.Авто тээврийн ажлын аюулгүй ажиллагааны шаардлага

8.5.1.Барилгын үйлдвэрлэлд тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ажил гүйцэтгэх үед энэхүү норм дүрмийн шаардлагаас гадна замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй ажиллагааны болсон ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах хууль дүрмийн шаардлагыг мөрдөнө.

8.5.2.Үйлдвэрлэлийн талбайд хөдөлгөөнийг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, үндсэн чиглэлийн схем боловсруулж, үзэгдэхүйц байранд байрлуулсан байвал зохино.

8.5.3.Автотээврийн хэрэгслээр ажил гүйцэтгэхэд дараах шаардлагуудыг хангасан байвал зохино.

- Өндөр температур,галын эх үүсвэртэй болгоомжтой харьцах хэм хэмжээг мөрдөх;
- Хий, агаарын орчныг зохих түвшний хяналтад байлгаж, аюултай хэмжээнд хүрэх

боломжийг хаах;

- Түлшинд уур ялгаралт, асгарах, гоожих үйл явцыг гаргахгүй байх.

8.5.4.Автотээврийн хэрэгслийн битүү зогсоолд дотоод шаталтын хөдөлгүүртэй машиныг асаалттай нь тавих, орхихыг хориглоно.

8.5.5.Хөдөлгүүр, тэжээлийн системийг халаах, мөстөлтийг арилгахдаа зөвхөн халуун агаар, халуун ус, уур хэрэглэхийг зөвшөөрнө.

Машин, тээврийн хэрэгслийн эд ангийг халаахад ил гал ашиглах, түлш, тосны системд гоожилт, асгаралт үүссэн нөхцөлд машиныг ашиглахыг тус тус хориглоно.

8.5.6.Удирдлага нь жолооч нарыг шугаманд гарахын өмнө тухайн ажлын нөхцөл, тээх ачааны онцлогын талаар мэдээлэл өгсөн байх үүрэгтэй.

8.5.7.Гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тусгайлан тэмдэглэгдсэн мөсөн гарцын зөвшөөрөгдөх даацыг тэмдэглэсэн заалт бүхий чиглэлийн дагуу гүйцэтгэвэл зохино.

Мөсөн дээгүүр явахдаа жолоочийн хаалгыг нээлттэй байлгана. Мөсөн дээгүүр явах үед жолоочоос өөр зорчигч тээвэрлэхийг хориглоно. Мөсөн гармыг нээх ба хөдөлгөөн хорих хугацааг тухайн гармыг өмчлөгч, эзэмшигч байгууллагын удирдлага тогтооно.

Мөсөн гарам дээр дараах үйлдлүүдийг хориглоно:

- түлш, шатахуун, тос цэнэглэх;

- мөсөн дээр хөргөлтийн системийн халуун усаа юүлэх, асгах;

- дур мэдэн хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх.

8.5.8.Тээврийн хэрэгсэлд зорчигч суулгах (буулгах) хэсэгт хүмүүсийн аюулгүй байдлыг хангасан, тусгайлсан гишгүүр, талбайгаар тоноглох буюу өөр бусад төхөөрөмж, тоноглол хийсэн байвал зохино. Тээврийн хэрэгслийн жолооч нь хөдөлгөөнд оролцохын өмнө хүмүүс орж, байрлалаа зөв эзэлсэн эсэхийг нягтлан тогтоосны дараа хөдөлгөөн эхлэх тухай урьдчилан мэдэгдэж байх үүрэгтэй.

8.5.9.Ажил гүйцэтгэх бүсэд автомашиныг ухрааж тавихдаа тухайн ажил гүйцэтгэгч аль нэг ажилчны дохио, удирдлагаар гүйцэтгэвэл зохино.

8.5.10.Нийтийн зориулалтын замаар овор ихтэй, хүнд жинтэй ачааг автотээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ, зохих ёсоор замын хөдөлгөөнийг зохицуулах байгууллагатай зөвшөөрөлцөж, автотээврийн хэрэгслээр овор ихтэй, урт, хүнд жинтэй ачаа тээвэрлэх (MNS5345:2003) стандартын шаардлагыг мөрдвөл зохино.

8.5.11.Автомашины тэвшний өргөнөөс илүү гарах хэмжээтэй ачааг тээвэрлэхдээ тэвшний өргөнд хоёр тийш адил хэмжээтэй илүү гарган ачсан байна.

- Ширхэгийн болон нунтаг материалыг автомашинд ачихад дараах шаардлагуудыг мөрдөнө:

- Ширхэгийн болон нунтаг материалыг машины тэвшний талбайд жигд тараасан байна;

- Тэвшний өндрөөс илүү гарга(н өрсөн ширхэгийн материалыг бэхэлсэн байна;

- Хайрцаг, савтай буюу бусад адилтгах ширхэгийн материалыг тэвшний шалан дээгүүр хөдөлгөөн дунд шилжих боломжгүйгээр, өөр хооронд нь нягт тулган өрж, бэхэлсэн байна.

8.5.13.Нэг ба хоёр голт болон урт ачааны зориулалт бүхий чиргүүлийг дор дурдсанаар тоноглож байвал зохино:

а)Бүхээг, ачааны хооронд суурилагдсан, эвхэгддэг буюу авагддаг тулгуур болон хашлагаар тоноглож байх;

б)Эргэх хүрдэт цагираган тэвшээр тоноглож байх.

Эргэх хүрдтэй тэвш нь ачаагүй хөдөлгөөний явцад түгжээтэй, ухрахад хязгаарлагч цоож тоноглолтой байна.

Чиргүүл нь зүтгүүртэй холбоход чиглүүлэгч шаардахааргүй тоноглолтой байвал зохино.

8.5.14.Аюултай ачааг автомашинаар тээвэрлэхэд Монгол Улсын замын хөдөлгөөний

дүрэм, MNS4978:2000 стандартын шаардлагыг мөрдөнө.

8.5.15.Аюултай ачааг тээвэрлэхдээ жолооч буюу барааг дагалдагч нь тухайн тээврийн хэрэгсэлд тодорхой зэрэг, нэр төрлийн ачаа тээвэрлэх зөвшөөрлийг ЗЦГ-аас авсан байвал зохино.

8.5.16.Баллонтой шахсан хий тээвэрлэх автомашин нь тэдгээрийг дэрлүүлэн байрлуулахад зориулагдсан, баллоны голчид таарсан эсгий жийрэг бүхий ухдастай тусгай тавиураар тоноглогдсон байна. Тээвэрлэлтийн үед баллон нь хамгаалалтын тагтай байвал зохино.

Халууны улиралд баллоныг элдэв тосон толбогүй брезентээр бүрж бүтээсэн байх шаардлагатай.

Баллон тээвэрлэж байгаа машины тэвшин дээр хүн суулгахыг хориглоно.

8.5.17.Тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхт, идэмхий, хурдан шатаж авалцах болон бусад аюултай ачаа, эдгээр ачааны хоргүйжүүлсэн сав, баглаа боодлыг холбогдох стандарт, зааврын дагуу хэрэглэнэ.

8.5.18.Хүчил, шүлт, шатдаггүй химийн шингэн бүхий савыг тээвэрлэхдээ автомашины тэвшин дээр босоогоор байрлуулан бат бөх даруулж, бэхэлсэн байх шаардлагатай. Автотээврийн хэрэгслээр зориулалтын бус саванд савлагдсан шатах, тослох материал, шатамхай шингэн, химийн бодисуудыг тээвэрлэхийг хориглоно.

8.5.19.Бензин шатахууныг зөвхөн тусгай зориулалтын торх, нягт эргэх бөглөө бүхий төмөр саванд тээвэрлэхийг зөвшөөрнө. Шатахуун тээврийн автомашин газардуулгын гинж, харин шатахуун хадгалах сав нь газардуулгатай байвал зохино.

8.5.20.Этилжүүлсэн бензинийг бусад ачаа болон хүмүүсийн хамт автомашины тэвшин дээр тээвэрлэхийг хориглоно.

9.Цахилгаан ба хийн гагнуурын ажлыг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

9.1.Ерөнхий шаардлага

9.1.1.Цахилгаан, хийн гагнуурын ажлыг гүйцэтгэх үед энэ бүлгийн болон Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хууль, MNS5150:2002, ГОСТ 12.3.003-86, ГОСТ12.3.036-84, Тал түймрийн улсын хяналтын дүрэм"-ийн шаардлагыг биелүүлбэл зохино.

9.1.2.Өндөрт гагнуурын ажлыг гүйцэтгэхдээ энэхүү норм ба дүрмийн 4.10, 4.14-д заасан шаардлагуудыг хангасан байвал зохино. Тэгэхдээ гагнуурчид нь цахилгааны аюулгүй ажиллагааны II -аас багагүй зэрэгтэй байвал зохино.

9.1.3.Цахилгаан, хийн гагнуурын ажил гүйцэтгэх тухайн төвшинд болон түүнээс доогуур байрлалтай эгнээнүүд (шатдаггүй хамгаалалтын болон шатдаггүй бамбай байхгүй үед) дэх ажлын байрууд нь шатамхай материалаас 5м-ээс багагүй, харин тэсрэх аюултай материал, төхөөрөмжөөс (хүчилтөрөгчтэй баллон, хийн генератор ба бусад) 10 м-ээс багагүй радиуст байвал зохино..

9.1.4.Бүтээцийн эд ангиудыг зүсэх, огтлох үед зүсэгдсэн хэсэг нь гэнэт тасарч унахаасурьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байвал зохино.

9.1.5.Шатамхай, хортой бодис, даралттай төрөл бүрийн шингэн, хий агуулж буй аппарат хэрэгсэл, сав, дамжуулах хоолой буюу цахилгаан техникийн тоноглолд хамаарах хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг ашиглагч байгууллагатай зөвшилцөж тохиролцоогүй, ажил эхлэх зөвшөөрөлгүйгээр дөлөөр халаах, огтлох, зүсэх, ширээс хийхийг хориглоно.

9.1.6.Шатамхай, хялбар шатдаг шингэн агуулж байсан саванд, тэдгээр шингэний ул мөрийг арилгах зохих боловсруулалт хийгдээгүй, сав доторх агаарын орчны хяналтгүйгээр ширээс, гагнуур хийхийг хориглоно.

Ийм саванд ширээс, гагнуур хийх үед тэдгээрийг саармаг хийгээр дүүргэж, нөхөн дүүргэлт хийж байх ба зөвхөн бөглөө, таглаа нээлттэй байх нөхцөлд гүйцэтгэвэл зохино.

9.2.Цахилгаан, хийн гагнуурын ажлыг гүйцэтгэх байр, технологийн үйл явцын аюулгүй ажиллагааны шаардлага

9.2.1.Хий дамжуулах хоолойг гагнуурын хошуу, зүсэгч хошуу, хуваарилагч хаалтны давхар шурганд, түүнчлэн хоолойн залгаасны хэсэгт бэхлэхдээ чангалагч даруулгаар бэхэлсэн байх шаардлагатай.

Хоолойг, давхар шурганы уртад хоёроос цөөнгүй хэсэгт, шатааж зөөлрүүлсэн ган (сүлжмэл) утсаар ороохыг зөвшөөрнө.

9.2.2.Нуман гагнуурт гагнуурын мөчлөгийн үргэлжлэх хугацааг бодолцон цахилгааны хамгийн их ачааллын үед найдвартай ажиллахаар тооцогдсон тусгаарлалт бүхий уян кабель хэрэглэвэл зохино.

9.2.3.Гагнуурын кабелийн залгаасыг шахалт, гагнуур, эсхүл ширээсээр гүйцэтгэж, дараа нь залгаасын хэсэгт тусгаарлалт хийвэл зохино.

9.2.4.Кабелийг гагнуурын тоног төхөөрөмжид давтаж хавтгайлсан буюу гагнаастай кабелийн төгсгөвчүүдээр залгасан байвал зохино.

9.2.5.Гагнуурын утсыг сунгах, зөөх, шилжүүлэх үед тусгаарлалтыг гэмтээхгүй байх, түүнийг ус, тос, ган татлага, дулаан дамжуулах шугамын халуун хоолойд хүрэх, шүргэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай. Гагнуурын утсыг халуун яндан хоолой, цэнэгтэй хүчилтөрөгчийн баллоноос 0,5 м, харин шатдаг хийн баллоноос 1 м-ээс багагүй зайд байлгавал зохино.

9.2.6.Тасалгаанд ил нуман гагнуур хийх гагнуурчны ажлын байр нь зэргэлдээх ажлын байр, хүмүүс зорчих хэсгээс 1,8 м-ээс багагүй өндөртэй үл шатах дэлгэц, хаалт самбаруудаар тусгаарлагдсан байх шаардлагатай.

Ил задгай агаарт гагнуурыг нэгэн зэрэг хэд хэдэн гагнуурчин бие биедээ ойрхон байрлалтайгаар хийх ба хүмүүсийн хөл, хөдөлгөөн ихтэй хэсэгт хийх тохиолдолд хаалт, хашлага хэрэглэвэл зохино.

9.2.7.Хур тунадастай нөхцөлд ил задгай газар гагнуурын ажил хийхийг хориглоно.

9.2.8.Гагнуурын байнгын цэг, байраас гадна гагнуурын ажил хийх ажлыг галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтны бичгээр олгосон зөвшөөрлөөр тогтооно.

Гагнуурын ажил хийх байрыг гал унтраах багаж хэрэгслээр хангасан байвал зохино.

9.2.9.Саван дотор болон бүтээцийн хөндийд цахилгаан, хийн гагнуурын ажил гүйцэтгэх үед ажлын байрыг агааржуулагчаар тоногдсон байвал зохино. Шингэрүүлсэн хий (пропан, бутан, аргон), нүүрсхүчлийн хий хэрэглэн гагнуурын ажлыг агааржуулалтын соролт дор гүйцэтгэнэ.

9.2.10.Саван дотор нэгэн зэрэг цахилгаан, хийн гагнуурын ажил гүйцэтгэхийг хориглоно.

Бага эзэлхүүнтэй, салхижуулалт муутай өрөө, тасалгаа, битүү сав болон худаг зэрэг газарт гагнуур хийх үед нүд, амьсгалын эрхтэнийг хамгаалах нэг бүрийн хэрэгсэл заавал хэрэглэх шаардлагатай.

9.2.11.Резервуар, худаг, бусад битүү саванд хийн гагнуур хийх үед бензин-зүсэгч хэрэглэхийг хориглоно.

9.2.12.Ган торх, саван дотор гагнуурын ажил гүйцэтгэх үед гадна суурилагдсан гэрэлтүүлэгч буюу 12В-оос илүүгүй хүчдлийн зөөврийн гэрэлтүүлэгч ашиглавал зохино.

9.2.13.Гагнуурын трансформатор, ацетилен генератор, шингэрүүлсэн хийтэй баллоныг гагнуур хийж буй битүү савны гадна байрлуулбал зохино.

9.3.Цахилгаан(гар) гагнуурын аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага

9.3.1.Хүчдэл бүхий цахилгаан гагнуурын аппарат, тэжээгүүрийн эх үүсвэрийн эд ангиудыг хаалт, хашлагаар битүүлж хаасан байвал зохино.

9.3.2.Гар цахилгаан гагнуурт хэрэглэх цахилгаан бариул нь тухайн эдлэхүүний стандартын шаардлагыг хангасан байвал зохино.

9.3.3.Цахилгаан гашуурын тоноглол (гагнуурын трансформатор, хувьсгуур г.м)-ыг тэжээлийн эх үүсвэрт залгуур, гал хамгаалагч буюу автомат салгуураар

дамжуулан холбоно. Харин сул явалтын хүчдэл 70 В-оос илүү байх үед гагнуурын аппаратыг автоматаар салгах автомат салгуур хэрэглэвэл зохино.

9.3.4.Цахилгаан гагнуурын тоног төхөөрөмжийн хүчдэлгүй төмөр эд ангиуд, тэрчлэн гагнаж байгаа бүтээц, эдлэхүүн нь гагнуур хийж байх бүх хугацаанд газардуулагдсан байх ба харин гагнуурын трансформаторын эх биений газардуулгын боолтыг хоёрдогч ороомгийн гүйдлийн буцах дамжуулагч утас холбогдох хавчаартай холбогдсон байвал зохино.

9.3.5.Гагнуурын гүйдэл дамжуулах утас, элементийн оронд, хөндлөн огтлол нь гагнуурын гүйдлийн аюулгүй байдлыг хангаж байвал, бүтээц болон ган шино ашиглаж болно.

Буцах утсыг орлуулан хэрэглэж байгаа элементийг хооронд нь боолт, хавчигч буюу гагнаасын тусламжтай найдвартай холбож өгвөл зохино.

9.3.6.Технологийн тоног төхөөрөмж, барилгын металл бүтээц, сантехникийн шугам сүлжээний яндан хоолой (ус дамжуулах, хий дамжуулах ба бусад), газардуулгын сүлжээний утсуудыг цахилгаан гагнуурын буцах утасны оронд хэрэглэхийг хориглоно.

9.4.Хийн баллоныг хэрэглэх, хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага

9.4.1.Хийн баллоныг хэрэглэх, хадгалахдаа даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн шаардлагыг хангасан байвал зохино.

9.4.2.Баллоныг задгай талбай дээр хадгалахдаа, тэдгээрийг тур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалах халхавчийг шатдаггүй материалаар хийсэн байвал зохино.

9.4.3.Шатдаг хийтэй, суурь тавиуртай баллоныг унагахгүйгээр барьж байх тусгайлсан үүр, чингэлэг болон бусад төхөөрөмжид босоо байдалд хадгалбал зохино.

Суурь тавиургүй баллоныг арал буюу тавиур дээр хэвтээгээр нь хадгална. Энэ тохиолдолд хураалттай баллоны өндөр нь 1.5 м-ээс илүүгүй, харин хавлага нь хаалт таглаатай, бүгд нэг тийшээ харсан байвал зохино.

9.4.4.Хоосон баллоныг хийтэй баллоноос тусгайд нь хадгална.

9.4.5.Хийтэй баллоныг зөөх тээвэрлэх, хадгалах, тавьж олгох, хүлээн авах ажлыг зөвхөн хийн баллонтой ажиллах тухай аюулгүй ажиллагааны сургалтад суралцаж, гэрчилгээ авсан хүн гүйцэтгэх ёстой.

9.4.6.Хийтэй баллоныг тогтвортой байршлыг хангасан, тусгай зориулалтын тэргэнцэр, чингэлэг бусад төхөөрөмж ашиглан зөөнө.

9.4.7.Ацетилений генераторыг орцонд, хүмүүсийн хөдөлгөөн ихтэй газарт, мөн агаарын шахуурга /компрессор/-ын болон агаар сэлгэлтийн ойролцоо байрлуулахыг хориглоно.

9.4.8.Хүчилтөрөгчтэй баллоныг ашиглах, хадгалах, зөөх үед шатахуун тосолгооны материалын сав, шугам хоолойд хүргэх, шүргүүлэх, мөргүүлэхгүй байх арга хэмжээ авах ба тостой ажлын хувцас, арчих материалд хүргэхийг хориглоно.

9.4.9.Хийтэй баллоныг цохигдох, нарны шууд тусгалаас хамгаалсан байхаас гадна халаалтын хэрэгслэлээс 1 м-ээс багагүй зайд байруулна.

9.4.10.Ажлын ээлж солигдох, засварлагын үеэр гагнуурын аппаратыг салгасан байна.

Гагнуурын резинэн хоолойг салгаж, гагнуурын щитэн дэх даралтыг бүрэн сулласан байвал зохино.

9.4.11.Ажил дууссаны дараа хийтэй баллоныг хадгалах зориулалтын байранд зөөн байрлуулж, гадны хүн оруулахгүй байвал зохино.

Хавсралт А
Энэхүү норм ба дүрэмд ишлэл авсан норматив
баримт бичгүүдийн жагсаалт

1. Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандартын эмхэтгэл. MNS1-1:2000. 1-р хэсэг: Техникийн ажлын журам, MNS 1-2 :2000. 2-р хэсэг: Стандарт боловсруулах арга зүй, MNS 1-3:2000. 3-р хэсэг: Стандартын бүтэц, бичлэг.
2. MNS4643-1998. Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө.
3. MNS'4967:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт.
4. MNS 4969:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм.
5. MNS4978:2000. Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага.
6. MNS0012-1-008:1985. Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Шуугиан. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
7. MNS 4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага.
8. MNS 4994:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
9. MNS4996:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлэгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага.
10. MNS 5002:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
11. MNS ISO 13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага.
12. MNS ISO 8194:2001. Цацрагаас хамгаалах -радио идэвхт бохирдлоос хамгаалах хувцас - Загвар сонголт, сорилт ба хэрэглээ.
13. MNS 5027:2001. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй. Эргономикийн ерөнхий шаардлага.
14. MNS 5028:2001. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг индикаторын гуурсаар тодорхойлоход тавигдах ерөнхий шаардлага.
15. MNS 5029:2001. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын шошго, тэмдэглэгээ.
16. MNS 5079:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
17. MNS 5080:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ.
18. MNS 5105:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсний хэмжээ, ерөнхий шаардлага.
19. MNS 5106:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга
20. MNS 5107:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга
21. MNS5145:2002. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөх дээд түвшин.
22. MNS5146:2002. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга, тэглэлт.
23. MNS5147:2002. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгаан статик орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин, хяналт тавих шаардлага.

- 24.MNS5148:2002.Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Радиогийн сүлжээний цахилгаан соронзон орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин, хяналт тавих шаардлага.
- 25.MNS5149:2002.Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн давтамжтай цахилгаан орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин, хяналт тавих шаардлага.
- 26.MNS5150:2002.Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага.
- 27.MNS5151:2002. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томъёо, тодорхойлолт.
- 28.MNS 4598:2003. Автотехникийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага.
- 29.MNS 4598:2003.Автотехникийн хэрэгслийн техникийн байдлын хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага.
- 30.MNS5345:2003.Овор ихтэй, урт, хүнд ачааны тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага.
- 31.MNS 5346:2003.Тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэхэд зуучлах үйлчилгээ.
- 32.MNS ILO-OSH:2003.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны талаарх удирдамж.
- 33.БНБД 10-01-99 Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо. Үндсэн журам. (ДБХС-ын 1999.05.12-ны өдрийн 125 тоот тушаал)
- 34.БНБД 2.09.12-87 Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм (УБХ-ны 1987 оны 64 тоот тогтоол)
- 35.БНБД 13-04-03 Барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жиийг норм. (ДБСайдын 2003.06.04-ний өдрийн 130 дугаар тушаал)
- 36.БНБД 12-01-03.Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт.(ДБСайдын 2003.12.18-ны өдрийн 252 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 1-д)
- 37.БНБД 31-04-03.Захиргаа ба аж ахуйн барилга (ДБСайдын 2003 оны 252 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4-д)
- 38.БД43-101-03 "Цахилгаан байгууламжийн дүрэм" (ДБСайдын 2003 оны 252 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 7-д)
- 39.Барилгачдын ажлын хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт /126 мэргэжлээр/ (ХЦХУХ, МҮЭ-ийн төв зөвлөлийн 1980 оны 6-р сарын 12-ны 150/97 дугаар тогтоол)
- 40.Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулах тухай. (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/243 тоот тушаал)
- 41.Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм (ДБСайдын 2003.06.06-ны 125 дугаар тушаал)
- 42.Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм.(ДБСайдын 2003.12.24-ны өдрийн 257 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт)
- 43.Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм. (Засгийн газрын 1996 оны 239-р тогтоолын хавсралт, Засгийн газрын 1998 оны 219-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан)
- 44.Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. (1996 он. 1998.11.12-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан)
- 45.Автотээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг, тооллого явуулах журам. (ДБХС, ХЗС, Сангийн сайд, Байгаль орчны сайдын хавтарсан 1999.04.22-ны өдрийн 100, 78, 54, 53 дугаар тушаалын II хавсралт)
- 46."Хүнд жинтэй", "Овор ихтэй" ачааг тээвэрлэх, буулгах журам. (Улсын материал, техникийн хангамжийн хорооны дарга, Тээврийн яамны сайдын хамтарсан тушаал)
- 47.Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм (ДБХСайдын

1998.03.30-ны өдрийн 88-р тушаал)

48.Ачаа өргөх краны оосорлогч дохиочны аюулгүй ажиллагааны заавар (ДБХСайдын 1998.03.30-ны өдрийн 88-р тушаал)

49.Гүүрэн төрлийн краны машинчийн аюулгүй ажиллагааны заавар (Улсын хянан байцаах газрын гишүүдийн хурлын 1992.04.20-ны өдрийн 04 тоот тогтоол)

50.Кранаар ачаа шилжүүлж ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагчийн ажлын заавар (Барилга-архитектур, техник хяналтын улсын хорооны 1985.03.15-ны өдрийн 13-ртогтоол)

51.Оосорлогч, дохиочны аюулгүй ажиллагааны заавар (Улсын хянан байцаах газрын гишүүдийн хурлын 1992.04.20-ны өдрийн 04 тоот тогтоол)

52.Монгол улсын галын аюулгүй байдлын тухай хууль. (1999 он)

53.Гал түймрийн улсын хяналтын дүрэм. (Засгийн газрын 1999 оны 209 дүгээр тогтоолын II хавсралт)

54.Мэргэжлийн боловсролын сургалтын тухай хууль (2003 он)

55.Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалт (Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999.08.13-ны А/204 тушаал)

56.Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалт (Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999.08.13-ны А/204 тушаал)

57.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох, газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт. (Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 78-р тушаал)

58.Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох, газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999.10.20-ны А/264-р тушаал)

59.Ажлын цагийг нэгтгэн бодох журам (Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 1-рхавсралт)

60.Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм (Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 2-р хавсралт)

61.Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм (Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 3-р хавсралт)

62.Уур, халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм (ДБХСайдын 1999.06.22-ны өдрийн 164 дүгээр тушаал)

63."Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм" (ЭХГУУурхайн сайдын 1995.12.05-ны өдрийн 330 дугаар тушаал)

64."Уурын ба усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм" ЭХГУУурхайн сайдын 1994.04.12-ны өдрийн 72 дугаар тушаал)

65.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм (Засгийн газрын 2000 оны 107 дугаар тогтоол)

66.Ажлын байрыг аттестатчилах журам (Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002.03.05-ны 26 дугаар тушаал)

67.Химийн хорт бодистой харьцан ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний жагсаалт (ЭМНХСайдын 2000.06.19-ний 171 дүгээр тушаал)

68.СНиП 2.05.07-91* Промышленный транспорт (УБХ-ны 1987 оны 107 тоот тушаал)

69.СНиП 2.09.02-85*(1991) Производственные здания. (ДБХ-ийн сайдын 1998 оны 23 тоот тушаал)

70.СНиП 23-05-95". Естественное и искусственное освещение. (ДБХ-ийн сайдын 1998 оны 23 тоот тушаал)

71.СНиП П-89-80*. (1995) Генеральные планы промышленных предприятий. (ДБХ-ийн сайдын 1998 оны 23 тоот тушаал)

72.ГОСТ 12.0.002—80.ССБТ. Термины и определения. С изм. № 1 от февраля 1999 г.

73.ГОСТ 12.1.046-85. ХХСС. Барилгын талбайн гэрэлтүүлэгийн норм.

74.ГОСТ 12.1.051-90. (СТ. СЭВ 6862-89). ХХСС. Цахилгааны аюулгүй ажиллагаа. 1000В -оос дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүс дэхь аюулгүй ажиллагааны зай.

75.ГОСТ12.1.007.0-75. ХХСС. Цахилгаан техникийн эдлэхүүн. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. (1978.08, 1981.08, 1984.01, 1988.09 сар. 4 удаа өөрчилсөн)

76.ГОСТ12.2.010-75.ХХСС. Хийн гар машин. Аюулгүй ажиллагаагны ерөнхий шаардлага. (1982.05, 1987.02, 1992.05 сар. 3 удаа өөрчилсөн.)

77.ГОСТ12.2.013.0-91.ХХСС. Цахилгаан гар машин. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага ба турших арга.

78.ГОСТ 12.2.022-80. ХХСС. Конвейер (Дамжуурга). Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. (1986.09, 1990.06 сар. 2 удаа өөрчилсөн)

79.ГОСТ12.2.003-86. ХХСС. Цахилгаан гагнуурын ажил. Аюулгүй ажиллагааны шаардлага. (1989.01 сар. 1 Удаа өөрчилсөн)

80.ГОСТ 12.3.020-80. ХХСС. Үйлдвэр дээр ачаа шилжүүлэн зөөх үйл явц. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. (1988.06 сар. 1 удаа өөрчилсөн)

81.ГОСТ12.3.033-84.ХХСС. Барилгын машин. Ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага.

82.ГОСТ12.3.036-84.ХХСС. Металлыг хийн дөлөөр боловсруулах. Аюулгүй ажиллагааны шаардлага. (1990.08. 1 удаа өөрчилсөн)

83.ГОСТ 12.4.059-89. ХХСС. Барилгын үйлдвэрлэл. Эд хогшлыг хамгаалах хашлага. Ерөнхий техникийн нөхцөл.

84.ГОСТ14254-96.Бүрхүүлээр хучигдсан хамгаалалтын зэрэг. Улс хоорондын стандарт (Код JP).

85.ГОСТ 27372-87. Барилга угсралтын ажлын дүүжин шат. Техникийн нөхцөл.

86.ГОСТ Р 50849-96* Барилгын хамгаалалтын бүс. Ерөнхий техникийн нөхцөл. Турших арга.

87.ГОСТ Р 51248-99. Краны газар дээрх төмөр зам. Ерөнхий техникийн шаардлага.

88.СНиП 12-03-2001 "Безопасность труда в строительстве. Часть1. Общие требования"

89.СП12-132-99 Безопасность труда в строительстве. Макеты стандартов предприятий по безопасности труда для организаций строительства, промышленности строительных материалов и жилищно-коммунального хозяйства. Принят и введен в действие постановлением Госстроя России от 15апреля 1999 г. №25.

90.СП 12-133-2000 Безопасность труда в строительстве. Положение о порядке аттестаций рабочих мест по условиям труда в строительстве и жилищно-коммунальном хозяйстве.

91.СанПиН 2.4.6.664-97. Гигиенические критерии допустимых условий и видов работ для профессионального обучения и труда подростков. Утверждены постановлением Главного государственного санитарного врача Российской Федерации № 5 от 04.04.1997г.

92.СанПиН2.4.548-96.Гигиенические требования к микроклимату производственных помещений. Утверждены постановлением Госкомсанэпиднадзора России от 1 октября 1996 г. №21.

93.МУ 2.4.6.665-97. Медико-биологические критерии оценки условий труда с целью определения противопоказаний и показаний к применению труда подростков. Утверждены постановлением Главного государственного санитарного врача Российской Федерации № 7 от 14 апреля 1997 г

95.Правила техники безопасности при эксплуатации электроустановок потребителей (4-е изд. С изм.) Утверждены Главгосэнергонадзором России 21 декабря 1984 г.

- 96.Правила эксплуатации электроустановок потребителей (ПЭЭП). Утверждены Главгосэнергонадзором 31 марта 1992 г. С изменениями и дополнениями от 30 сентября 1993 г. № 42-6/ 8-ЭТ и от 14 ноября 1994 г. № 42-6/34-ЭТ.
- 97.Правила охраны электрических сетей напряжением до 1000 В. Утверждены постановлением Совета Министров СССР 11 сентября 1972 г. № 667.
- Правила охраны электрических сетей напряжением свыше 1000 В. Утверждены постановлением Совета Министров СССР 26 марта 1984 г. №255.
- 98.ПОТ РО-200-01-95. Правила по охране труда на автомобильном транспорте. Утверждены приказом Министерства транспорта России 13 декабря 1995 г. № 106.
- 99.ТОИ Р 66-01-95*-ТОИ Р 66-60-95. Типовые инструкции по охране труда для работников строительства, промышленности строительных материалов и жилищно-коммунального хозяйства. Утверждены постановлением Минстроя России от 13 марта 1995 г. № 18-22.
- 100.Типовые отраслевые нормы бесплатной выдачи специальной одежды, специальной обуви и других средств индивидуальной защиты работникам промышленности строительных материалов, стекольной и фарфоро-фаянсовой промышленности (приложение № 1) и Типовые отраслевые нормы бесплатной выдачи специальной одежды, специальной обуви и других средств индивидуальной защиты работникам, занятым на строительных, строительно-монтажных и ремонтно-строительных работах (приложение № 3). Утверждены постановлением Минтруда России от 25 декабря 1997г. №66.
- 101.Типовые нормы бесплатной выдачи специальной одежды, специальной обуви и других средств индивидуальной защиты работникам сквозных профессий и должностей всех отраслей экономики. Утверждены постановлением Минтруда России от 30 декабря 1997 г. № 69.
- 102.Правила обеспечения работников специальной одеждой, специальной обувью и другими средствами индивидуальной защиты. Утверждены постановлением Минтруда России от 18 декабря 1998 г. № 51.
- 103.Положение о проведении планово-предупредительного ремонта производственных зданий и сооружений. Утверждено постановлением Госстроя СССР от 29 декабря 1973 г. № 279.
- 104.Положение о проведении планово-предупредительного ремонта и технической эксплуатации производственных зданий и сооружений предприятий промышленности строительных материалов. Утверждено Минпромстройматериалов СССР 5 ноября 1979 г.
- 105.СанПин 2.2.3.757-99 Работа с асбестом и асбестосодержащими материалами. Утверждены главным государственным санитарным врачом Российской Федерации 28 июня 1999 г.

НЭР ТОМЪЁО БА ТҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Нэр томъёо	Тодорхойлолт	Тодорхойлолтыг өгөхдөө үндэслэсэн баримт бичгийн нэр
1	2	3
1.Барилга байгуулалт	Үр дүн нь барилгын бүтээгдэхүүн буюу барилгын материал болон эдлэхүүн болох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрөл	БНБД10-01-99-ийг харгалзан энэхүү баримт бичгээр тодорхойлогдоно.
2.Барилгын үйлдвэрлэл	Уур амьсгалын ямарч нөхцөлд бүх төрлийн барилга ба байгууламжийг барих, их засвар хийх, техникээр шинэчлэн тоноглох, сэргээн засварлах үед хийгдэх бэлтгэл ба үндсэн барилга угсралтын болон тусгай барилгын ажлын цоцолборын гүйцэтгэл	Барилгын тухай хууль болон БНБД 10-01-99-ийг харгалзан энэхүү баримт бичгээр тодорхойлогдоно.
3.Барилгын үйлдвэр	Барилга,байгууламжийн барилгын бүтээц, хийцээр хэрэглэхэд зориулан эдлэхүүнийг үйлдвэрийн нөхцөлд бэлтгэх	Адил
4. Барилгын материалын үйлдвэр	Барилгын эдлэхүүнийг бэлтгэх болон барилга, байгууламжийн барилгын бүтээцийг бүрдүүлэхэд зориулан материал (үүний дотор ширхэгийн)-ыг үйлдвэрийн аргаар хийх	Адил
5.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	Байгалийн баялгийг бэлэн бүтээгдэхүүн болгоход шаардлагатай хөдөлмөрийн зэвсгийг хэрэглэн өөртөө бүх төрлийн түүхий эдийн боловсруулалт, үйлдвэрлэл, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх ба барилга, байгуулалтыг агуулсан хүмүүсийн үйлдлийн цогц	Согласно Федеральному закону РФ «Об основах охраны труда в Российской Федерации» от 17 июля 1999г. № 181-ФЗ
6.Үйлдвэрлэлийн дэвсгэр нутаг	Баригдсан ба баригдах барилга, байгууламжууд байрлах,барилгын буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад зориулан олгогдсон газар нутаг	Энэ нормоор.
7.Барилгын талбай	Барилгын байгууламж, түүнчлэн машин, материал, бүтээц, үйлдвэрлэлийн болон ахуйн үйлчилгээний байр,сууцыг байрлуу-лахад зориулан, зохих журмын дагуу тусгайлан олгосон үйлдвэрлэлийн	Адил
8. Хөдөлмөрийн аюулгүй нөхцөл	Ажиллагчдад үйлчлэх үйлдвэрлэлийн хортой буюу аюултай хүчин зүйлс байхгүй, эсхүл тогтоосон норматив хэмжээнээс хэтрээгүй байх хөдөлмөрийн нөхцөл	Согласно Федеральному закону РФ «Об основах охраны труда в Российской Федерации» от 17 июля
9. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага	Хөдөлмөрлөх явцад ажиллагчдын биеэ авч явах, учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөл бололцоог хангах үүднээс хууль тогтоомжийн акт, норматив техникийн баримт бичиг, дүрэм, заавраар тогтоосон хэм хэмжээ	MNS 4967: 2000- аар.
10.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй (хөдөлмөр хамгаалал)	Хөдөлмөрийн процесст хүний ажлын чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж аюулгүй ажиллагааг хангаж чадах нөхцлийг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт,техник, ариун цэвэр-эрүүл ахуйн арга хэмжээний систем	MNS 3108-81, MNS12.0.002-87 стандартуудаар
11.Хөдөлмөрийн нөхцөл	Хөдөлмөрлөх явцад ажилтны хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийн нийлбэр	MNS4967: 2000-аар.

12.Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл	Тодорхой нөхцөлд ажиллагчдын эрүүл мэндэд нөлөөлж гэмтээх буюу түүний эрүүл мэндэд нөлөөлөх үйлдвэрлэлийн хүчин зүйл	MNS4967:2000-аар
13.Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл	Ажиллагчдын эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх буюу ажиллах чадварыг бууруулах, зарим тохиолдолд тэдний үр удамд нөлөөлөх уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлс	MNS4967:2000-аар
14.Аюултай бүс	Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлс хүнд нөлөөлж болзошгүй орон зай	По ГОСТ 12.0.002
15.Өндөрт угсрах ажил	Газрын гадаргуу, хучилтаас, эсхүл дээр нь угсрах буюу засварлах бүтээц, тоног төхөөрөмжтэй шууд харьцах ажлыг гүйцэтгэж байгаа газрын гадаргуугаас 5м-ээс илүү өндөрт хийгдэх ажил. Энэ ажлыг гүйцэтгэхэд ажиллагчдыг унахаас урьдчилан хамгаалах үндсэн хэрэгсэл нь хамгаалалтын бүс юм.	Энэ баримт бичгээр.
16.Ажлын байр	Ажиллагчид хөдөлмөрийн гэрээний дагуу гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотой байнга ба түр хугацаагаар оршин байх буюу шилжин явах, ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтад байх газар	MNS4967:2000-аар
17.Байгууллага (хуулийн этгээд)	Өмчлөх ба захиран зарцуулах хэлбэрээс хамаарах –гүй үйлдвэр, албан байгууллага буюу бусад хуулийн этгээд. (Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл)	В соответствии с Гражданском кодексом РФ. 1-я часть. Монгол Улсын иргэний хууль I хэсэг. 25-р зүйл.
18.Ажил олгогч	Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээд	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль
19.Ажилтан	Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн.	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль
20.Хөдөлгөөнт машин	Нэг ажлын байрнаас нөгөө ажлын байр луу өөрийн явалтаар зөөвөрлөх боломжтой буюу тээврийн	Энэ баримт бичгээр.
21.Суурин машин	Угсралтын ажил хийгдэж байгаа ажлын бай-ран дээр суурилуулах шаардлагатай буюу өөрийн явалтаар зөөвөрлөх боломжгүй машин.	Энэ баримт бичгээр.
22. Тохирлын гэрчилгээ	Зохих журмын дагуу баталгаажуулалтад тэнцсэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүнд баталгаа-жуулалтын байгууллагаас олгох баримт бичиг.	Монгол улсын Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль.
23. Агаарын бохирдол	Эрүүл мэндэд хортой буюу зарим талаар аюултай, биет байдлаасаа хамаарахгүй бодисоор бохирдсон агаарын дурын бохирдол	148-р конвенц. "Ажлын байран дахь агаарын бохирдол, дуу шуугиан ба доргионоос болж үүсэх мэргэжлийн эрсдлээс хөдөлмөрчдийг хамгаалах тухай"

24. Шуугиан	Эрүүл мэндэд хортой буюу зарим талаар аюултай, эсхүл сонсголгүй болгож мэдэх бүх төрлийн дуу чимээ	148-р конвенц. "Ажлын байран дахь агаарын бохирдол, дуу шуугиан ба доргионоос болж үүсэх мэргэжлийн эрсдлээс хөдөлмөрчдийг хамгаалах тухай"
25. Доргион	Эрүүл мэндэд хортой буюу зарим талаар аюултай, хүйий биед хатуу биетээр дамжин үйлчлэх бүх төрлийн доргио.	148-р конвенц. "Ажлын байран дахь агаарын бохирдол, дуу шуугиан ба доргионоос болж үүсэх мэргэжлийн эрсдлээс хөдөлмөрчдийг хамгаалах тухай"

**АЖИЛЛАЖ БАЙГАА ҮЙЛДВЭРИЙН БОЛОН ХОРООЛЛЫН
ДЭВСГЭР НУТАГ, ТАЛБАЙД БАРИЛГА-УГСРАЛТЫН АЖИЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН АКТ**

.....ХОТ

.....ОНЫ....сар....өдөр

(үйлдвэр (баггууллага), хорооллын нэр)

Бид захиалагчийн төлөөлөгч _____

(овог нэр, албан тушаал)

барилга угсралтын ажлыг хариуцаж буй ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөгч _____

(овог нэр, албан тушаал)

нарын бүрэлдэхүүнтэй дор гарын үсэг зурсан комисс барилга угсралтын ажил гүйцэтгэх тухай энэхүү актыг үйлдэж дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:
Захиалагч (байгууллага, албан газар) нь доорх солбицолоор хязгаарлагдсан дэвсгэр нутаг, талбайд _____

(тэнхлэгийн нэр, зургийн дугаар, тэмдэглэгээ)

шинээр барилгын ажил явуулахад зориулж, ерөнхий гүйцэтгэгчийн хариуцлагатай ажилтны удирдлагын дор _____ оны _____ сарын _____-ээс эхлэн _____ сарын _____-ыг хүртэл _____

(ажлын нэр)

хийж гүйцэтгэхээр тохиролцов.

Барилга угсралтын ажил эхлэхийн өмнө уг ажлыг аюулгүй гүйцэтгэхийн тулд дараах арга хэмжээ авна.

№	Авах арга хэмжээний нэр	Биелүүлэх хугацаа	Хариуцах хүн
1.			
2.			
3.			

Захиалагчийн төлөөлөгч

/гарын үсэг/

Барилга угсралтын ажил хийгдэж байгаа газрын ойролцоох ашиглаж буй объектийг эзэмшигч байгууллагын төлөөлөгч

/гарын үсэг/

Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөгч

/гарын үсэг/

Тайлбар: Хэрэв актад заасан хугацаанд уг ажил дуусаагүй бол шинээр акт тавьсны дараа үргэлжлүүлнэ.

АЮУЛТАЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН БҮСИЙН ХИЛ ХЯЗГААР

Г.1.Өргөх краны ачаа шилжүүлэх бүсэд орсон талбай, тэрчлэн баригдаж буй барилгын ойролцоох талбайд орсон аюултай бүсийн хилийг кранаар шилжүүлж буй ачааны гадна талын хамгийн их оврын (хэвтээ дүрслэлийн) байгуулалтын захын цэг буюу барилгын хананаас авсан хэмжээс дээр шилжүүлж байгаа ачааны хамгийн их оврын хэмжээ ба ачааны унах үеийн нисэлтийн хамгийн бага зайг (хүснэгт Г-1-ын дагуу) нэмсэн хэмжээгээр авна.

Хүснэгт Г.1.

Ачаа (аливаа зүйл) унаж болох өндөр, м	Зөөвөрлөж (унаж) буй зүйлийн нисэлтийн хамгийн бага зай, м	
	Кранаар шилжүүлж буй ачаа унах тохиодолд	Барилга дээрээс аливаа зүйл унах тохиолдолд
10 хүртэл	4	3.5
20 хүртэл	7	5
70 хүртэл	10	7
120 хүртэл	15	10
200 хүртэл	20	15
300 хүртэл	25	20
450 хүртэл	30	25
Тайлбар: Ачаа (аливаа зүйл) унаж болох өндрийн завсрын утганд түүний нисэлтийн хамгийн бага зайг интерполяцийн аргаар тодорхойлж болно.		

Г.2.Цахилгаан гүйдлийн үйлчлэлээр аюул үүсч болох газарт хязгаар тогтоох аюултай бүсийн зайг хүснэгт Г.2-т үзүүлэв.

Хүснэгт Г.2.

Хүчдэл, кВ	Цахилгаан төхөөрөмжийн хаалт, хамгаалалт, тусгаарлагдаагүй ил байгаа хэсгээс (цахилгаан төхөөрөмж, кабель ба гүйдэл дамжуулагч утас) болон тухайн хүчдэлд ажиллаж байгаа агаарын цахилгаан дамжуулах шугамны доод захын хамгийн ойрхон утаснаас тэдгээрийн аюултай бүсийн хил хүртлэх зай, м
1 хүртэл	1.5
1-ээс 20 хүртэл	2
35-аас 110 хүртэл	4
150-аас 220	5
330	6
500-гаас 750 хүртэл	9
800 (тогтмол гүйдэл)	9

Г.3.Хорт бодисын үйлчлэлээр аюул үүсч болох газарт хязгаар тогтоох аюултай бүсийн хилийг MNS 4990:2000 стандартаар тодорхойлогдох хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч байгаа эсэхэд хийсэн хэмжилтээр тодорхойлно.

Г.4.Машин, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгийн ойролцоох аюултай бүсийн хязгаарыг, хэрэв бэлтгэн нийлүүлэгч заавар буюу паспортад өөр бусад нэмэлт шаардлага тавигдаагүй бол, 5 м дотор тогтоож болно.

**Аюултай буюу хортой хүчин зүйл үйлчилж байгаа газарт
Ажил гүйцэтгэх зөвшөөрөл**

200...оны.....сарын.....- ны өдөр олгов.
200 оны сарын - ны өдөр хүртэл хүчинтэй.

1.Ажлыг удирдагч _____
(Овог нэр, албан тушаал)

2.Гүйцэтгэх ажил _____
(ажлын нэр, байршил, түүнийг гүйцэтгэх нөхцөл)

3.Ажил гүйцэтгэж байгаа газарт үйлчилж байгаа буюу тухайн газарт гүйцэтгэж байгаа ажлаас үл хамааран үүсч болох үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлс:

4.Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө авсан байх арга хэмжээнүүд:

№	Авах арга хэмжээний нэр	Биелүүлэх хугацаа	Хариуцах хүн
1	2		4

Ажил эхэлсэн	он	сар	өдөр	цаг	мин.
Ажил дууссан	он	сар	өдөр	цаг	мин.

5. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх явцад авсан байх арга хэмжээнүүд:

№	Авах арга хэмжээний нэр	Биелүүлэх хугацаа	Хариуцах хүн
1	2	3	4

6.Ажил гүйцэтгэх бүрэлдэхүүн:

Овог нэр	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны бүлэг, мэргэжил	Хөдөлмөрийн нөхцөлтэй танилцаж, зааварчлага өгсөн	Хөдөлмөрийн нөхцөлтэй танилцсан
1			
2			
3			
г.м.			

7.Ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгосон: _____
(байгууллагын удирдлагын тушаалаар томилогдсон бүрэн эрхт төлөөлөгчийн

(овог нэр, албан тушаал, гарын үсэг)

Ажил гүйцэтгэх зөвшөөрөл хүлээн авсан: _____
(албан тушаал, овог нэр, гарын үсэг)

8.Барилга угсралтын ажилд бичгээр өгсөн ажиллаж байгаа үйлдвэрийн (байгууллагын) зөвшөөрөл.

Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар авсан арга хэмжээг зөвшөөрсөн: _____

(ажиллаж багтаа үйлдвэр буюу байгууллагын бүрэн эрхт төлөөлөгчийн албан тушаал, овог нэр, гарын үсэг)

9.Хөдөлмөрийн нөхцөл ба ажлын байрыг шалгав. Ажил гүйцэтгэх зөвшөөрөлд заасан үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны арга хэмжээг биелүүлсэн байна

гэж үзээд ажил эхлэн гүйцтгэхийг зөвшөөрөв.

(Овог нэр, албан тушаал, гарын үсэг, он, сар, өдөр)

10. Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг _____хүртэл сунгав.

(Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг олгосон этгээдийн гарын үсэг, он, сар, өдөр)

11.Ажлыг бүрэн гүйцэт дуусгав. Материал, тоног, багаж хэрэгслийг татаж авав. Хүмүүсийг чөлөөлөв. Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг хаав.

Ажлын удирдагч:

(он, сар, өдөр, гарын үсэг)

Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг олгосон этгээд:

(он, сар, өдөр, гарын үсэг)

Тайлбар:-Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг хоёр хувь үйлдэнэ. (нэг дэх хувь нь ажил гүйцэтгэх зөвшөөрлийг олгосон этгээдэд, 2 дахь хувь нь ажлыг хариуцан гүйцэтгэгчид байна). Ажиллаж байгаа үйлдвэрийн газар нутаг дээр хийгдэж байгаа ажилд ажил гүйцэтгэх зөвшөөрлийг 3 хувь үйлдэнэ. (3 дахь хувийг ажиллаж байгаа үйлдвэрийн хариуцлагатай этгээдэд олгоно).

ХАВСРАЛТ Е

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ ЗАЙЛШГҮЙ АВСАН БАЙВАЛ ЗОХИХ
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨРӨЛ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАЙР
(НӨХЦӨЛ) -НЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЖАГСААЛТ**

Е.1.Цахилгаан дамжуулах агаарын шугам, хий, нефтийн бүтээгдэхүүн дамжуулах хоолой, хурдан гал авалцах буюу шатамхай шингэн, шатамхай буюу шингэрүүлсэн хий агуулах бүхий хамгааллалтын бүсэд ачаа өргөгч кран болон бусад барилгын машинаар гүйцэтгэх ажил

Е.2.Худаг, цооног, битүү ба хүрэхэд бэрх орон зайд гүйцэтгэх бүх төрлийн ажлууд.

Е.3.Патогенийн бохирдолтой хөрстэй (хогийн цэг, малын сэг булсан газар г.м) газарт болон газар доорх цахилгааны шугам, хийн хоолой ба бусад газар доорх аюулд өртөж болзошгүй шугам сүлжээ байрлах хамгаалалтын бүсэд хийгдэх газар шорооны ажлууд.

Е.4.Аюултай хүчин зүйлүүд үйлчлэх нөхцөлтэй ажиллаж байгаа газарт урсгал засвар хийх, тоног төхөөрөмжийг задалж буулгах, түүнчлэн засвар буюу ямар нэгэн барилга угсралтын ажил гүйцэтгэх

Е.5.Аюултай буюу аюул гарах боломжтой газарт өөр төрлийн ажлыг зэрэгцүүлж гүйцэтгэх тохиолдол.

Е.6.Ашиглаж байгаа төмөр зам ба автозамын зорчих хэсэг буюу далантай нийлсэн газарт ажил гүйцэтгэх (холбогдох яам, тамгын газраас гаргасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норматив баримт бичгүүдээр тодорхойлогдоно).

Е.7.Хийн аюултай ажил гүйцэтгэх.

ХАВСРАЛТ Ж

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭМЭГДЭЛ ШААРДЛАГА
ТАВИГДАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЖАГСААЛТ БА БАРИЛГЫН
АЖЛЫН НЭР ТӨРӨЛ**

- Автоклавчин
- Агаарын шугаман замын жолооч (Вагонетчик)
- Асбестын тугнуурчин
- Аспираторчин
- Асфальтбетончин (асфальт дэвсэгч, чанагч)
- Барилгын машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн машинч, жолооч нар
- Бункерчин
- Вулканжуулагч (Хатууруулагч, бэхжүүлэгч)
- Галд тэсвэртэй доторлогоо хийгч
- Лантуучин (копорчин)
- Нунтаглагч битийг цэнэглэгч
- Туузан дамжуургын зөөгүүрчин

- Тэсэлгээчин
- Үйлдвэрийн тоосгон яндангийн хоолой угсрагч
- Усан бууны ажилчин
- Уурхайн зуухны үнс буулгагч
- Хагас вагоны нээлхийгээр материалыг зөөвөрлөх, буулгахад туслах ажилчин
- Хар тугалгаар гагнуур хийгч
- Хатаагуурын галч
- Хийн гагнуурчин
- Хортой найрлага бүхий будгаар будах будагчид
- Хүчил шүлттэй холбогдолтой ажил гүйцэтгэгчид
- Шавар, зуурмаг бэлтгэгч
- Шарах камер болон автоклавын цэнэглэгч-буулгагч
- Шохой тунгаагч
- Эрдэс хөвөн, шилэн ширхэгийн болон асбест, полиуретан дулаан тусгаарлагч
материалтай ажиллагч дулаан тусгаарлагч
- Модон материалыг ялзралтаас болон галын аюулаас хамгаалах химийн
бодисоор гүйцэтгэх ажил
- Өндрийн ажил
- Радио идэвхт бодис хэрэглэх ажил
- Тээврийн болон ачаа өргөгч хэрэгслийг ашиглан ачиж, буулгах ажил
- Хоёр метрээс илүү гүнтэй ухсан газарт газар шорооны болон хөрсний бэхэлгээ
хийх, буулгах ажил.
- Цахилгаан төхөөрөмжийн засвар, ашиглалтын ажил
- Цахилгаан гагнуурын ажил
- Цахилгааны монтёр
- Этилтэй бензин хэрэглэх ажил

**Барилга угсралтын ажлыг эхлэхэд _____объектын бэлэн
байдал болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагаар талбайн
гадна ба дотор гүйцэтгэх бэлтгэл ажилтай холбогдуулан үйлдэх
үлгэрчилсэн акт**

200....оны.....сарын.....-ны өдөр

Комиссын бүрэлдэхүүн:

Барьж байгаа үйлдвэрийн (захиалагч байгууллагын техникийн хяналтын) удирдагч
(захирал) : _____

(овог нэр, албан тушаал)

барилгын гэрээт, ерөнхий гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгчид: _____

(Байгууллагын нэр, төлөөлөгчийн овог нэр, албан тушаал)

бэлтгэл ажлын үед ажил гүйцэтгэх, мэргэжлийн туслан гүйцэтгэгч байгууллагын
төлөөлөгчид: _____

(Байгууллагын нэр, төлөөлөгчийн овог нэр, албан тушаал)

барилгын гэрээт ерөнхий гүйцэтгэгч байгууллагын ажилтны төлөөлөгч _____

(овог нэр)

нарын бүрэлдэхүүнтэй комисс талбайн гадна ба доторх бэлтгэл ажил, үүний дотор
хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн ажиллагчдыг,
200....онысарын.... -ны өдрийн байдлаар гүйцэтгэсэн эрүүл ахуйн үйлчилгээгээр
хангасан байдлыг үзэж магадлаад, доорх асуудлын тухай актүйлдэв.

1. Үзлэгт _____

(талбайн гадна ба доторх бэлтгэл ажил, үүний дотор

ажиллагчдыг эрүүл ахуйн үйлчилгээгээр хангасан байдал)

ажил хамрагдав.

2.Техник зохион байгуулалтын баримт бичиг (барилгын зохион байгуулалтын төсөл
болон ажил гүйцэтгэх төсөл) -т заасан ажлыг гүйцэтгэсэн байна.

*(байгууллага ба ЗБТ, АГТ-ийг боловсруулагчийн нэр. Зургийн дугаар ба түүнийг
зохиосон он, сар, өдөр)*

3.Үзлэгт хамрагдсан ажлууд нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт болон
норм ба дүрмийн шаардлагыг зөрчсөн (буюу оруулсан) байна.

(ямар нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөнийг зааж өгнө)

Комиссын шийдвэр

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм ба дүрмийн шаардлагатай нийцүүлэн,
төсөлд тусгасан ажлын хэмжээнд ажлыг гүйцэтгэсэн байна.

Энэ байдлыг үндэслэн объект дээр барилга угсралтын үндсэн болон тусгай ажлыг
эхлэн гүйцэтгэхийг зөвшөөрч байна.

Барьж байгаа үйлдвэрийн (захиалагч байгууллагын техникийн хяналтын)
удирдагч (захирал) _____

(гарын үсэг)

Барилгын гэрээт ерөнхий гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч _____

(гарын үсэг)

Мэргэжлийн туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч _____

(гарын үсэг)

Барилгын гэрээт ерөнхий гүйцэтгэгч байгууллагын
ажилтны төлөөлөгч _____

(гарын үсэг)

Тайлбар: Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын удирдлага нь хөдөлмөрийн хяналтын төлөөлөгчид комисс ажиллах байр болон он, сар, өдрийн тухай урьдчилан мэдэгдэнэ. Шаардлагатай тохиолдолд комиссын ажлын хэсэгт улсын хяналтын буюу мэргэжлийн байгууллагыг оролцуулна.

ХАВСРАЛТ К

БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГМ- ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГТ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ШИЙДЭЖТУСГАХ ҮНДСЭН ЗУРАГ ТӨСЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

К.1.Технологи-зохион байгуулалтын баримт бичиг (Барилгын ЗБТ, АГТ г.м) нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норматив шаардлагуудыг хангасан ажлын арга, техник хэрэгслийг тодорхойлох хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар тодорхой зураг төслийн шийдлийг агуулсан байна.

Тухайн шийдлийг боловсруулахын тулд зөвхөн үндэслэл болгон оруулахыг зөвшөөрсөн зураг төслийн шийдлийг хөдөлмөр аюулгүйн норм ба дүрмээс иш татаж өөрчлөхийг хориглоно.

К.2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар зураг төслийн шийдэл боловсруулахын тулд доорх зүйлүүдийг өгөгдөл болгон авна:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт болон нормативын баримт бичгийн шаардлагууд;

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэх талаар авсан үлгэрчилсэн шийдвэр, ажиллагчдыг хамгаалах хэрэгслийн каталоги ба лавлах гарын авлага;

Барилгын материал, бүтээц, эдлэхүүнийг хэрэглэх явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах бэлтгэн нийлүүлэгч үйлдвэрийн зааварчилгаа;

Ажлын явцад хэрэглэх машин, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгч үйлдвэрийн зааварчилгаа.

К.3.Барилгын ба үйлдвэрлэлийн талбай, ажлын хэсгийн зохион байгуулалтаар зураг төслийн шийдэл гаргахдаа заавал ажил гүйцэтгэх нөхцөл, технологитой холбоотой үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийг тодруулах, технологи-зохион байгуулалтын баримт бичигт тэдгээрийн үйлчлэх бүсийг зааж, тодорхойлж өгвөл зохино. Тэгэхдээ ачаа өргөгч машинтай холбоотой аюултай бүсийг зураг төсвийн баримт бичиг (зохион байгуулалтын төсөл)-д, бусдыг нь үйлдвэрлэлийн баримт бичиг (ажил гүйцэтгэх төсөл)-д тодруулж өгнө.

К.4.Ажиллагчдын амралтын талбай, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн байр сууц, түүнчлэн явган хүний ба авто замыг аюултай бүсийн гадна байрлуулвал зохино.

К.5.Хэрэв барилга ба байгууламжийг барих (шинэчлэх) явцад, аюултай бүсэд, кранаар ачаа шилжүүлэх газар болон барьж байгаа барилгын дэргэд дэхь ашиглаж буй иргэний буюу үйлдвэрийн барилга ба байгууламж, авто буюу явган хүний зам болон бусад хүмүүс байж болзошгүй газрууд орох тохиолдолд, тэнд аюултай бүс бий болох нөхцлийг сэрэмжлүүлсэн шийдлийг, тэр дундаа доорх зүйлүүдийг урьдчилан анхааруулах шаардлагатай.

а)Кранаар ачаа шилжүүлэх газрын дэргэд:

хүмүүс оршиж байгаа газарт аюултай бүс бий болохыг хориглохын тулд краны ажлын бүсийг албаар хязгаарласан байвал зохино. Иймээс цамхагт краныг, түүний ажлын

бүсийг хязгаарлах нэмэгдэл хэрэгслээр тоноглохыг зөвлөх;
ажлын бүсийн хил рүү очих краны сумны эргэлтийн хурд нь хамгийн бага хүртэл шилжүүлэх ачаанаас бүсийн хил хүртэл 7 м-ээс бага зайд хязгаарлагдсан байна;
аюултай бүсийн хязгаараас 7 м-ээс бага зайд байрлах хэсэгт ачааг шилжүүлэхдээ ачааг унагахгүй байлгах, хамгаалалтын буюу даатгалын хэрэгслүүдийг ашиглавал зохино;

б)Барьж байгаа (шинэчилж байгаа) барилгын ойр хэсгүүдэд: барилгын эргэн тойронд ачаа өргөгч кранаар шилжүүлж байгаа ачааны өндөртэй адил буюу илүү өндөр хамгаалах дэлгэцийг байрлуулах шаардлагатай;

краны ажлын бүс ньГ хамгаалах дэлгэц байрлах газар дахь барилгын хүрээний гадна талд шилжүүлж байгаа ачаа гарахгүй байхаар хязгаарлагдсан байвал зохино.

К.6.Барилгыг буулгах (нураах) үе дэхь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах зураг төслийн шийдлээр дараах зүйлүүдийг тодотгож өгвөл зохино: буулгах (эвдэх) аргыг хэрэглэх үе дэхь аюултай бүсийн хэмжээ; бүтээцийн өөрийн эвдрэлийг хассан, ажил гүйцэтгэх дэс дараалал; бүтээцийг эвдлэх болон ачаалах явц дахь тоос үүсгэгчийг дарах арга хэмжээ.

К.7.Зураг төслийн шийдэлд ажиллагчдыг өндрөөс унахаас урьдчилан сэргийлж дараахь зүйлүүдийг тусгана:

өндөрт гүйцэтгэх ажлын хэмжээг, конвейрийн буюу томсгосон хэмжээтэй хийц, эсхүл угсралтын крангүй аргыг хэрэглэх замаар, аль болох хорогдуулах;

эхний ээлжинд байнгын хашлага хаалтын үүрэг давхар гүйцэтгэх хийц (хана, хавтан, балконы хашлага болон хаалганы хонгил) -үүдийг хийх арга хэмжээ авах;

баригдаж байгаа барилгын бүтээц ба эзэлхүүн төлөвлөлтийн шийдэлд нийцсэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан хашлага бүтээцийг хэрэглэх;

хамгаалалтын бүсийг бэхлэх арга ба газрыг зааж өгөх; Үүнээс гадна доорх зүйлүүдийг тодруулж өгвөл зохино. Үүнд:

тухайн төрлийн ажил буюу тусгай ажилбарыг гүйцэтгэхэд зориулагдсан хэрэгслүүд; ажиллагчдыг ажлын байр руу гаргах хэрэгсэл, явах зам чиглэлийг тогтоох;

шаардлагатай тохиолдолд - барилгын урт бүтээцүүдийг алсаас тэнжээгээр багцалж задлах, ачаа өргөх зориулалтын хэрэгсэл.

К.8.Кранаар шилжүүлж байгаа барилгын бүтээц, эдлэхүүн, материалыг өндрөөс унах, түүнчлэн угсрах буюу өрж хураах явцад тэдгээрийн тогтвортой байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зураг төсөлд дараах зүйлсийг зааж өгвөл зохино. Үүнд:

шилжүүлж байгаа ачааны даац, шинж чанар болон түүнийг ажлын байранд хүргэх дөхөмтэй байдлыг харгалзан үзэж, ширхэгийн буюу үйрмэг материал, түүнчлэн бетон буюу зуурмагийг зөөж шилжүүлэх чингэлэг буюу сав, баглаа боодлын багцлах хэрэгсэл;

угсрах ба оосорлох нөхцөл, шилжүүлж байгаа ачааны хэмжээ, жинд нийцсэн ачаа өргөх зориулалтын хэрэгсэл (ачаа өргөх тэнжээ, траверс, угсралтын хавчуур);

бүтээцийн элементүүдийг угсрах ба өрж хураахдаа зураг төсөлд заасан газарт буюу түүний ойролцоо байрлалд хүргэх нөхцлийг хангасан оосорлолтын арга;

барилгын бүтээцийн элементүүдийг тогтвортой хадгалах тоног хэрэгсэл (пирамид, кассет)

барилгын бүтээц, эдлэхүүн, материал ба тоног төхөөрөмжийг хураах арга, дараалал; бүтээцийг бүрэн гүйцэт болон түр бэхлэх арга; барилгын хог, хаягдлыг зайлуулах арга; жижиг ширхэгийн материал буюу эд юмс унах боломжтой бүсэд хүмүүс байх шаардлагатай үед хамгаалалтын саравч буюу хучилтын бүтээц, төхөөрөмжийн байрлал;

К.9.Барилгын машин, механизм буюу тоног төхөөрөмж хэрэглэн ажил гүйцэтгэх тохиолдолд дараах шаардлагуудыг анхаарвал зохино:

барилгын ажлын техноЛоги, нөхцөлөөс хамааруулан хэрэглэх машин механизмын нэр төрөл, тэдгээрийг байрлуулах газар, ажлын дэглэмийг сонгох;

хүмүүс оршин сууж байгаа газарт аюултай бүс үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд машины үйлчлэх бүсийг хязгаарлах арга хэмжээ авах, түүнчлэн машины ажлын бүсийн хашлага хэрэглэх;

ухсан нүх шуудууны эрэг, овоолсон шороо зэрэг дээр машин механизм байрлах онцгой нөхцөл.

К.10.Суваг, шуудуу ухах .шаардлагатай болон тэдгээрт хүн ажиллаж байгаа үед барилга угсралтын ажлыг гүйцэтгэхийн тулд дараах зүйлүүдийг тодорхойлсон байна: зураг төсвийн баримт бичигт (барилга зохион байгуулалтын төсөлд) -барилгын машин, материалаас ирэх ачааг тооцсон хүнхээлийн бэхэлгээгүй налуугийн аюулгүй эгц эрэг буюу бэхэлгээ хэрэглэх шийдвэр;

үйлдвэрлэлийн баримт бичигт (ажил гүйцэтгэх төсөлд) дээрхээс гадна-улирлын өөрчлөлтэй холбоотойгоор хүнхээлийн тогтвортой байдлыг хангах болон хянах нэмэлт арга хэмжээ;

бэхэлгээний төрөл ба тэдгээрийг байрлуулах технологи, түүнчлэн хүмүүс өгсөх, буух шат байрлах газар.

К.11.Ажиллагчдыг цахилгааны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:

түр цахилгаан төхөөрөмжийн ашиглалт, хүчний ба гэрэлтүүлгийн цахилгааны сүлжээний түр хүчдлийн тодорхойлолт ба трассыг сонгох, гүйдэл гаргагч хэсгийн хаалт хамгаалалтын төхөөрөмж болон хуваарилах буюу дамжуулах систем ба багаж хэрэгслийн суурилалтын заавар;

цахилгаан тоног төхөөрөмжийн төмөрлөг хэсгийн газардуулгыг хийх арга;

онц аюул осолтой байранд ажил гүйцэтгэх үед, түүнчлэн үүнтэй ижил нөхцөлтэй байрны гадна ажил гүйцэтгэхэд авах хамгаалалтын нэмэлт арга хэмжээ;

цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны арга хэмжээ.

К.12.Ажилтанд үзүүлэх үйлдвэрлэлийн хортой хүчинзүйл (цаг агаарын бичил уур амьсгалын тааламжгүй нөхцөл, дуу шуугиан, доргио, тоос болон ажлын бүсийн агаар дахь хорт бодис) -ээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай:

гүйцэтгэх ажлын нөхцөл болон технологитой уялдаатайгаар үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл үүсч болох ажлын хэсгийг тодорхойлох; ажиллагчдын хамгаалах хэрэгслийг тодорхойлох;

шаардлагатай үед, аюултай болон хортой бодис хадгалах талаар тусгайлсан арга хэмжээг авах;

К.13.Радио идэвхт изотоп агуулсан болон ионжуулагч цацрагийн үүсгүүрийн багаж хэрэгслүүд буюу лазерийг хэрэглэж байгаа тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг зайлшгүй авбал зохино.

Ишлэл авсан бусад баримт бичгүүдийн жагсаалт

- [1] Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1977 оны 148-р конвенц. "Ажлын байран дахь агаарын бохмрдол, дуу шуугиан ба доргионоос болж үүсэх мэргэжлийн эрсдлээс хөдөлмөрчдийг хамгаалах тухай"
- [2] Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1981 оны 155-р конвенц "Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба үйлдвэрлэлийн орчны тухай".
- [3] Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Асбест хэрэглэх үе дэхь хөдөлмөр хамгааллын тухай" 162-р конвенц.
- [4] Хөдөлмөрийн гэрээний нөхцлийг тодорхойлох тухай зөвлөмж (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 128 тоот тушаалын хавсралт)
- [5] Байгууллагын ажилтан, албан хаагчдын орон тооны норматив боловсруулах зөвлөмж (Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2001.09.18-ны өдрийн хурлаар батлагдсан)
- [6] Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам. (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 33 тоот тушаалын хавсралт).
- [7] Хамтын гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг дүгнэх тухай зөвлөмж (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000.04.11-ний өдрийн 92 тоот тушаалын хавсралт)